PRODUCTION

**РАЖИВ ГАНДИЙН НЭРЭМЖИТ
ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**




# НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ,
# СУДАЛГАА ИННОВАЦИ

**УРИА:** ШИНЭ САНААГАА ШАВХАГДАШГҮЙ НӨӨЦ, ХӨГЖЛИЙН БОЛОМЖ БОЛГОЁ

# АГУУЛГА


1. Д.БУЯНДЭЛГЭР- СУРАЛЦАХУЙН ХАНДЛАГА БА НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ

2. Б.МЯДАГБАДАМ- МБС-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

3. И.ОЮУНЧИМЭГ- КУРСЫН АЖИЛ УДИРДАХ

4. Ц.ХУЛАН- БҮЛГИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

5. М.АЛТАНЦЭЦЭГ- ЦАХИМ СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ДЭЭШЛҮҮЛЭХ

6. П.ЧУЛУУНБАТ- L@BSOFT ПРОГРАМААР UNITRAIN АШИГЛАН ЭЛЕКТРОНИКИЙН ЧАДАМЖ ОЛГОХСУРГАЛТ

7. Д.ОДГЭРЭЛ- ҮЙЛДВЭРЛЭЛ СУРГАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХНЬ

8. Б.АНХБАЯР- БОЛОВСРОЛЫН МАРКЕТИНГ

9. В.ГЭРЭЛЦЭЦЭГ- ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙ

10. Д.БУЯН-АРВИЖИХ- НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ,АЖИЛ ОЛГОГЧ,СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

11. Б.БИЛГҮҮНБАЯР- ГЭР АХУЙН НӨХЦӨЛД ГАЛЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,COVID-19 ВИРУСЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨМЖ

12. Х.БАТЖАРГАЛ - ҮУПК ЦАХИМ НОМЫН САН




# УДИРТГАЛ

Нийт ажилтны ур чадварын түвшинд нөлөөлөхүйц сургалт нь байгууллагын чухал хөрөнгө оруулалтын нэг гэж хэлж болно. Байгууллагын хүсэл сонирхолд ч мөн нөлөөлдөг. Үүнээс гадна ажилтны боловсрол,мэргэжлийн ур чадвар нь харилцагчийг татах,урт хугацаанд хамтран ажиллах,байгууллагын нэр хүнд болон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг нэмэгдүүлэх амин асуудлын нэг юм.

Сургалтын гол зорилго юу вэ?

Багш,ажилтны ажлын байран дээрх хөгжлийн асуудал нь тэдний ажлын байран дээрх тогтворгүй байдал,дотоод дүрэм журмыг баримтлах,ажиллах урам зоригийн нэгээхэн хөшүүрэг бөгөөд сургалтын гол зорилго нь тэднийг дэмжих, хөдөлмөрийн бүтээмжийг нь нэмэгдүүлэх улмаар байгууллагын сургалтын үйл ажиллагааг сайжруулах явдал юм.

Цар тахлын үе,цахим орчинд үйл ажиллагаа явагдаж байгаа энэ үед ч гэсэн сургалт нь үр дүнтэй байх хэрэгтэй,сургалтын агуулгыг тодорхойлохдоо багш,ажилтны хэрэгцээнд тулгуурласан,байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг арилгах, үр ашигтай,мөн багш,ажилтнуудад өгөөжтэй байхаар зохион байгуулахыг зорьлоо.

ҮУПК-ийн багш,ажилтны ажлын байран дээр хөгжихөд зориулсан сургалтын хэрэглэгдэхүүнийг эмхэтгэн ном болгон гаргаж байгаа анхны бүтээлийн алдаа оноог та бүхэн дэнсэлж,ажилдаа хэрэгжүүлэх олон санааг олж харна гэдэгт итгэж байна.

Эцэст нь Алиса Гайхамшгийн Оронд цувралаас дараах эшлэлийг татъя:

**“Та харж байгаа биз дээ яг одоо энд та яаж ч гүйсэн нэг л газраа байгаа биз дээ. Хэрвээ та хаа нэг тийшээ хүрье гэвэл одоогийнхоос ядаж 2 дахин хурдан гүйх хэрэгтэй !“**





# СУРАЛЦАХУЙН ХАНДЛАГА БА НЭЭЛТТЭЙ СУРГААЛЬ

/Захирал: Д.Буяндэлгэр/



Боловсрол бол үйлчилгээ.
Сургууль бол үйлчилгээний байгууллага юм.




Багш суралцагчийн үйл ажиллагаа болон сургалтын үйл ажиллагаа эрс өөрчлөгдөж байна.

- Өнөөдөр бүгдийг сурч, мэдээд багш болдог тогтолцоо өөрчлөгдөж байна.
- Багш нь шавиа хөгжүүлэх явцдаа өөрөө хөгждөг мэргэшил болсон.
- Багш нь тасралтгүй хөгжиж, суралцах шаардлагатай болж байна.



**Сурах**

**Суралцахуй /Суралцах/**



**Сургах**

**Багшлахуй /Удирдан чиглүүлэх, зөвлөх, манлайлах/**




Иргэд мэдлэг, ур чадварыг орон зай, цаг хугацаанаас хамаарахгүйгээр олж авч байна. Сургуулийн тухай уламжлалт ойлголт эрс өөрчлөгдөж байна.

Аж үйлдвэрийн хувьсгал /Аж үйлдвэр 4.0, Аж үйлдвэр 5.0/

Нанотехнологи, биотехнологи, мэдээллийн технологийн асар хурдацтай хөгжил нь хурдан хугацаанд өөрчлөлт бий болгохыг шаардаж байна.

Мэдлэг, ур чадвар шилжих процесс явагдаж байна.

Маргаашийн ажиллах хүчнээс маш өндөр мэдлэг, ур чадвар шаардана.

Энэ хирээр бидний мэргэжил гэх ойлголт мэргэшил болж, ажиллах хүчин бэлтгэх хугацаа уртасна.

Сургууль ур чадварын эрэлт, дутагдлыг дангаараа олгож, шийдвэрлэх боломгүй болж байна.

Удахгүй ажиллах хүчний олон ажлын байрыг хиймэл оюун ухаан /Робот/ орлохоор байна.

Бид Роботын хийж чадахгүй зөвхөн хүнд байх зөөлөн ур чадваруудыг сургуулиар олгоход түлхүү анхаарч, хөтөлбөрийн эрс шинэчлэл хийх шаардлагатай болно.

Цахимаар, зайнаас сургалтыг зохион байгуулах, орой, эчнээ, нэг өдрийн г.м сургалтын олон арга хэлбэр, арга зүйг нэвтрүүлэх хэрэгцээ бий болж байна.




- Задлан шинжлэх сэтгэлгээ ба шинийг сэдэх чадвар
- Суралцах идэвх ба суралцах стратеги
- Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чадвар
- Шүүмжлэлт сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх чадвар
- Уран сэтгэмж, өвөрмөц байдал, идэвх санаачилга
- Манлайлал ба нийгэмд нөлөөлөх чадвар
- Технологи ашиглах, хянах шалгах чадвар
- Технологи загварчлах, програмчилах чадвар
- Уян хатан чанар ба стрессээ зохицуулах чадвар
- Эргэцүүлэн бодох болон асуудал шийдвэрлэх

**Ур чадварын төрлүүд**

- Асуудал шийдвэрлэх
- Хувийн менежмент хийх
- Бусадтай ажиллах
- Технологи ашиглах

Бидний төгсөгчид удахгүй бие, биетэйгээ өрсөлдөхөөс гадна /хоорондоо өрсөлдөхөөс илүү/Роботтой өрсөлдөх шаардлага тулгарна. Төгсөгчид маань нэг эзэмшсэн мэргэжил, өнөөдөр олж авсан мэдлэг, чадвараараа насан туршдаа ажил, хөдөлмөр эрхэлж, орлого олох боломж улам бүр хумигдана.Байнга сурч, хөгжих, мэргэжлээ солих шаардлагатай болно.

Тиймээс бид суралцагчдаа суралцах чадвартай болгох ёстой. Насан туршийн боловсрол, сургалтын тогтолцоо эрчимтэй хөгжиж байгааг анзаарч, хэрэгжүүлэх хэрэгтэй болж байна.

## ХУВЬ ХҮНИЙ ХЭРЭГЦЭЭНИЙ УР ЧАДВАРЫН СУРГАЛТУУД

/Хоол хийж сурах, дугуйгаа нөхөж сурах/

Хэрэгцээний сургалтанд хамрагдаж байгаа хүн ч мэргэжил эзэмшиж, тэднийг ажлын байртай болгох юм шиг өрөөсгөл ойлголт

Хамтран ажилладаг аж ахуйн нэгжтэй хамтарсан технологийн судалгаа

Суралцагчдаа стнартаас давсан ур чадвар олгож хамтран ажиллах замаар шинэ санаа, бүтээл гаргах

Боловсролын түншлэлийн хамтын ажиллагаа

Энэ бүхэн нь багшлахуйд өөрчлөлт бий болгож багшийг судлаач, инноваци бүтээгч, төгсөгчид тавьж байгаа ур чадварыг эзэмшин манлайлагч байхыг шаардаж эхэлж байна.




- Сургууль төвтэй сургалтаас Суралцагч төвтэй сургалт руу шилжилт хийгдэж байна.
- Сургуулиас гадна сургалтын олон хэлбэр, зохион байгуулалт бий болж байна.
- Бид Сургуулиа, сургалтаа хүн бүрт, хэрэгцээнд нь тохируулан нээлттэй байлгаж, үйлчилж чадаж байна уу ...
- Иргэний, үйлдвэрлэлийн ажилтны суралцахуйн зорилгод нийцсэн хөтөлбөр, багшлахуйн хангалттай чадамжтай нөөц бүрэлдэхүүн байна уу ...
- Суралцахаар ирсэн нэг хүн, хүн бүрийн зорилгыг хангаж чадаж байна уу...
- Давтан сургаж, мэргэшүүлж байна уу ...
- Ажилгүй иргэн, ажил мэргэжлээ өөрчилж суралцах байгаа иргэд бидэнд хандаж байна уу...
- Насан туршийн сургалтын тогтолцоо байна уу ...
- Жилд ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс ихэвчлэн бүрдсэн нийтийг хамарсан элсэлт авч хүнийг сургаж байна.
- Судалгаагаар Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын 80 орчим хувь нь боломж олдвол гадаадад суралцана гэсэн эрмэлзэлтэй байна.
- 45 –аас дээш насны хүн ам цаашдаа 2 дахин ихсэх хүн ам зүйн төлөв байна.




БИД ЭНЭ БҮХЭНД БЭЛЭН БАЙНА УУ ???
БИД ЭНЭ ИХ ӨӨРЧЛӨЛТИЙГ ЭХЛҮҮЛСЭН ҮҮ ??? !!!
ӨӨРСДӨӨСӨӨ БАЙН БАЙН АСУУЖ САЙТАР ТУНГААН БОДОЦГООЯ.

**БИД СУРГУУЛИА УЛАМ БҮР НЭЭЛТТЭЙ БОЛГОЖ БАЙЖ, ХӨГЖЛИЙГ ТҮҮЧЭЭЛНЭ .**

# ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ



# МБС-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

**Сургалтын менежер: Б.Мядагбадам**



Эрхэм багш нартаа энэхүү онлайн пост хэлбэрээр хүргэж байгаа сургалтын товч мэдээллийг хүргэе.

1. Сургалтыг чиглүүлэн хөтлөх багш та сургалтын аргаа хэрхэн тодорхойлсон бэ? гэдэг нь сургалтыг төлөвлөн хэрэгжүүлэхэд чухал алхмын нэг билээ. Иймд та бүхэнд эхний сэдэв “Сургалтын арга” -аа зөв тодорхойлж, суралцагчдын сурах арга барилд зөв нөлөөлөх талаарх 1-р хэсгийг хүргэж байна. Энэ чиглэлээр үргэлжлэл бий.

2. Сургалтыг хүргэх гол үйл явц бол хичээл. Иймд танд хичээлийн талаар судлаачдын гаргасан хамгийн чухал ойлголтуудыг нэгтгэн хүргэж байна. Үргэлжлэл мэдээж бий.

3. Өнөөдөр дэлхий нийтээр цар тахалтай тэмцэж байгаа цаг мөчид бид Цахим сургалтын арга зүйг эзэмшиж, түүнийг хөтлөн явуулах туршлага хуримтлуулж байна. Иймд цахим хичээлд юу чухал болох талаарх мэдлэгийг хуваалцаж байна. Цаашид ч бид цахим сургалтыг үндсэн сургалтын нэг хэлбэр болгох нь тодорхой байна.

4. Сүүлийн хэсэг МБС-ын үнэлгээний арга зүй сэдвийн хүрээнд үнэлгээний эрх зүйн орчин хэрхэн бүрдсэн, үнэлгээний төрөл, хэлбэр, аргын талаар хуваалцаж байна. Бид ЕБС-ыг олгож байгаа тул дэлхийн үнэлгээний чиг хандлагын талаар, МУ боловсролын тогтолцоондоо үнэлгээний орчинг хэрхэн бүрдүүлж байгаа, МБС-ын үнэлгээний холбогдолтой дүрэм журамд үнэлгээний нэгдсэн ойлголтыг хэрхэн тусгасан талаар оруулаа. Үргэлжлэл бий...

### Та бүхэнд хүргэх сургалтын эхний хэсгийг “Сургах арга” гэж юу вэ? гэдэг асуултаар эхлүүлье.

Суралцагчдад мэдлэг, арга барил, чадвар дадал зэргийг төлөвшүүлэх зорилготой багшийн сургах үйлдлийн тогтолцоо юм. Тухайлбал: Тайлбарлан ярих, үзүүлэх, туслах, хянах, алдааг засах, үнэлж дүгнэх” гэх мэт байж болно”.

### Орчин үеийн сургалтын үндсэн зорилго:

1. Суралцагчдад стандартын хэмжээний ба сурагчдын хүсэж байгаа, тэдэнд хэрэгцээтэй байгаа суурь мэдлэгийг эзэмшүүлэх (өгөх бус, олгох бус)

2. Суралцагчдад бие даан суралцах арга барил, чадварыг эзэмшүүлэх

3. Суралцагчдад бие хүний эрхэм зан чанаруудыг төлөвшүүлэх, нийгэмшүүлэх \бие дааж сэтгэн бодох, шийдвэр гаргах, хариуцлага хүлээх, шударга байх зэрэг\



*Ишлэл: Ш.Ичинхорлоо “Сургах арга” УБ хот 2012 он 11 тал*

## Сурган хүмүүжүүлэх арга




## Сургалтын аргын үүрэг

Арга гэдэг нь үйлдэл учраас түүнийг цаашид оноож зөв хэрэглэх нь нэн зүйтэй. Энэ нь өвөрмөц үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал: Аргаар дамжин сургалтын зорилго, агуулга хэрэгжихийн хамт мөн сургалтын технологийн бусад элемент буюу бүрэлдэхүүн хэсгийг хооронд нь холбож хөдөлгөөнд оруулдаг " Амилуулагч" хүчин зүйл бөгөөд түүнийг сургалтын амин сүнс гэж үзэж болно.
Ишлэл Ш.Ичинхорлоо "Сургалтын арга зүйч шинэчлэл" УБ 2013 он 8 тал

## Сургалтанд гарч буй зөрчил:

Сургалтын агуулга тогтмол шинэчлэгдэж байгаа бөгөөд ихэнхи багш нар хуучин арга технологиор хэрэгжүүлсээр байгаа явдал нь шинэ зөрчил үүсгэн улмаар сургалтын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Багш бүр суралцагч төвтэй сургалтын арга зүйг эзэмших, суралцагчийг сурч танин мэдэх олон төрлийн үйл ажиллагаанд татан оруулах, суралцагчдаар мэдлэг бүтээлгэх, тэдэнд чадвар эзэмшүүлэх, хандлагыг зөв төлөвшүүлэх арга зүйгээ тогтмол шинэчлэн сайжруулж байх шаардлага бидний өмнө тулгарч байна. Иймд та бүхэн сургалтын арга зүйн дараах дасгалыг заавал хийгээрэй.



*Ишлэл: Ш.Ичинхорлоо "Сургах арга" УБ хот 2013 он 8 тал*

ДААЛГАВАР №1

Ажилбар А: Багш бүр өөрийн танхимын сургалтын 1 тогтсон арга, цахим сургалтын 1 тогтсон аргыг сонгон бусаддаа танилцуулах

Ажилбар Б: Тухайн багшийн танилцуулсан 2 сургалтын аргуудад SWOT хийх /тухайн багшийн секцийн багш нар багаараа/

## Сургалтын аргыг үр өгөөжтэй хэрэглэх зарим

1. Сурган хүмүүжүүлэх аргын талаар мэргэжлийн ном сэтгүүл зэргийг уншиж бүтээлч багш нарын туршлагыг судлан шинэ шинэ аргыг танин мэдэх
2. Мэддэг олон арга дотроосоо тухайн нэг сэдвийг амжилттай заахад таарч тохирох аргуудыг оновчтой сонгож авах, түүнээ хэрэгжүүлэх
3. Сонгож авсан аргуудыг тухайн хичээл дээр яаж хэрэглэхээ сайтар бэлтгэж боловсруулах
4. Бэлдэж боловсруулсан аргуудаа тухайн хичээлийн явцад бүтээлчээр хэрэглэх
5. Тухайн хичээл дээр хэрэглэсэн аргууд хэр үр дүнтэй яаж хэрэглэвэл илүү үр дүнтэй болох талаар дүгнэлт хийх

## Арга эзэмшсэн багшийн сургалтын хэрэглэгдэхүүн № 1

Хичээлийн тухай товчхон:

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___

___




## Хичээл гэж юу вэ?

Хүн төрөлхтний бий болгосон туршлагыг дараа үедээ өвлүүлэх шинэ техник технологийг эзэмшүүлэх, хүнээр хүн хийх, хүнийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, гэгээрүүлэх үндсэн хэлбэр бол хичээл мөн гэж тодорхойлсон байна.

Тодорхой зорилт, зорилго агуулга арга зүй үнэлгээ бүхий багш суралцагчийн бүтээлц хамтын үйл ажиллагаар хичээл гэнэ гэсэн тодорхойлолт мөн байна.

## Хичээлийн технологи

Сэтгэл судлал, сурган хүмүүжлүүлэх болон удирдлагын ухааны зүй тогтолд тулгуурлан боловсруулсан хамгийн оновчтой аливаа үйлдлийг гүйцэтгэх эрэмбэ дэс дараалалтай зүйл

## Бид юунд суралцах хэрэгтэй байна вэ?



Багш хичээлээ заадаг байдлаасаа “татгалзаж” т ухайн судлагдахууныг хүүхдээр бүтээлгэх “жорд” суралцах нь багшийн үүрэг

Энэ үед багшийн зохион байгуулагч, чиглүүлэгч, холбогч, хөтлөгч, зааварлагч, удирдамжаар хангагч, үнэлэгч,, үлгэрлэгч, /зааварлагч, сонсогч, хүндэтгэл шаардлагыг хослуулагч, манлайлагч, тэвчээртэн/ байх чанар үүрэг илүү тод илрэх учиртай

## Хичээлд тавигдах шаардлага




## Ээлжит хичээлийн технологи

Сургалтын зорилго агуулгыг хэрэгжүүлэх эхлэх /орц/ үргэлжлэх/ явц/ дуусах үе /гарц/ шаттай. 80 минут үргэлжлэх сургах, сурах үйл явц. Эл хугацаа суралцагчийг сайн хүн болгоход хүүхдийн хөгжил төлөвшилд бодит нөлөө үзүүлэхүйц байх учиртай.

## Сайн төлөвлөлт ажилтын эх үндэс




Арга зүйн бичиг баримтын гол үр дүн нотолгоо бол **ээлжит хичээлийн төлөвлөлт** юм. Хичээл зорилго, зорилтоос шалтгаалан хэд хэдэн төрөл байдаг.

- Шинэ мэдлэг олгох буюу шинэ материал судлах хичээл
- Чадвар дадал бий болгох буюу дадлагын хичээл
- Бататгал буюу хэрэглээ болгох хичээл /семинар/
- Баяжуулан системчлэх хичээл / төсөл болон интеграц хичээл/
- Хяналт шалгалтын хичээл
- Анализ хичээл гэх мэт

Ямар хичээл заах гэж байгаагаасаа шалтгаалан багш ээлжит хичээлийн төлөвлөлтөө хийнэ.

### ДААЛГАВАР №2

Ажилбар А: Та өөрийн боловсруулсан ээлжит хичээлд дүгнэлт хийж, төлөвлөлтөө хэрхэн хийснээ тодорхойлж бичнэ үү?



Ажилбар Б: Ээлжит хичээлийг цахим болон танхимын сургалтын үед хэрхэн төлөвлөх талаар багаар ярилцан секц бүлгээрээ өөрсдийн мэргэжлийн онцлогыг тусгасан Дадлага болон онолын хичээлийн 1 ээлжит загварыг боловсруулан бусад секцийнхэнд танилцуулна уу?



## Цаг үетэй нийцсэн Цахим сургалт Дэлхийтэй хөл нийлэх гарц





## Хичээлийн агуулга

- Цахим сургалтыг хөгжүүлэх шат
- Цахим хэрэглэгдэхүүний стандарт
- Агуулга боловсруулахад анхаарах асуудал
- Агуулга түгээх арга замууд технологи
- Тогтвортой байдлын төлөвлөгөө
- Хүний нөөц

## Цахим сургалт хөгжүүлэлтийн үе шатууд

- Төлөвлөгөөгөө гарга
- Загвараа боловсруул
- Цахим агуулга хөгжүүл
- Сургалтандаа нэвтрүүл
- Зогсотгүй сайжруул






## Төлөвлөгөөгөө гарга ✅

- Цахим хичээл гэж юуг ойлгож шаардаж байна вэ?
- Агуулга нь юу вэ?
- Хэнд зориулсан?
- Дэлгэцийн загвар зохиомж
- Хичээл боловсруулах баг?
- Ямар сувгаар зорилтот бүлгүүдэд хүргэх?
- Зорилтот бүлэг хичээлийг юунд, хэрхэн ашиглах вэ

## Цахим сургалтыг багаараа төлөвлөе

- 3 хүн нэг баг
- Хичээлийн сэдвээ сонго
- Төлөвлөгөөгөө гарга /дэлгэц дээрх асуултыг ашиглаж болно
- 15-20 мин
- Тоймлон бич, зур /вакуум цаас дээр гаргацтай/



## Цахим хэрэглэгдэхүүн, стандарт




## Хичээлийн цахим хэрэглэгдэхүүний амьдралын цикл






## Агуулга боловсруулалт, анхаарах асуудал

- Товч тодорхой
- Хялбар дүрслэлтэй
- Жишээ баримттай
- Цаг хуваарилалттай
- Визуал элементтэй
- Зөв загвартай
- Хялбар дүрслэлтэй



## Цахим хэрэглэгдэхүүний төрөл



Интернэтээс дараах англи болон монгол түлхүүр үгээр хайж цахим сургалтын сүүлийн үеийн технологи болон аргай зүйн мэдээллийг авч уншиж болно.

- E-Learning implementation
- E-learning trens
- E-material standards
- E-learning methodology




Цахим хичээл бүхий Монгол вэб хуудсууд

- http://econtent.edu.mn цахим сурах бичиг маягаар
- http://econtent.edu.mn/content/inter-active.html интерактив хичээлүүд
- https://www.youtube.com/watch?v=o8oA8GqGijY Youtube дэх хичээлүүд
- https://www.youtube.com/watch?v=-jBtliQa-Ucw&list=PLFTS5BGRd6ns-VNuHXIIfPyhcHBt2hUwn
- http://kl2.mn/math
- https://www.youtube.com/channel/UCe42RlIVS9lN68w7Pult3Zw Хан Академийн хичээлүүдийг орчуулсан Монгол хичээл
- https://laptop.gov.mn/aguulga/theory.php?subsuject=5
- https://www.geogebra/org/mV3kB-cURs?doneurl=%2 Fgroup%2Fmatrrial%-2Fid%2FVz7AGSKyG/gi/Vz7AGSKy#ma-tetrial/WkZH2HTD
- https://urchadvar.itpd.mn/ Багш танхимд 45 минутын хичээл заасан бичлэг
- https://teacher.sur.mn/default.aspx илтгэлүүд

## Дүн, шалгалт- ойлголтоос татгалзаж, багш, суралцагчийн үнэлгээ хийх арга зүйд суралцахуй

1. Дэлхийн боловсрол сургалтын үнэлгээг хэрхэн хийж байгаа туршлага:
2. БСШУСЯ-ны багш, суралцагч, сургалтын үнэлгээний талаар:
3. ХНХЯ-наас баримталж буй үнэлгээ зохион байгуулах, үнэлгээний төрөл, ялгааны талаар




## Олон улсын үнэлгээний системээс

| Улс | Хувь | Түвшин, тэмдэглэгээ | | Дүнгийн тодорхойлогч |
|---|---|---|---|---|
| Герман | 0-100 | 12 | 1-6 хүртэлх цифр /1+, 1, 1- г.м/ | Маш сайн, онцгой амжилттай, сайн дундаж оноонoос дээгүүр шаардлагахангаагүй үр дүнд хүрээгүй г.м |
| Финлянд | 0-10 | 10 | 0-10 цифр | Маш сайн, сайн тогтвортой, хангалттай, амжилтгүй, шалгалтадунасан г.м |
| Америк | 0-100 | 13 | A, B, C, D, F үсэг /A+, A, A- г.м/ | Хамгийн шилдэг, шилдэг, маш сайн гүйцэтгэсэн, их сайн, сайн, сайнд дөхсөн, дундаж, дунджаас дээгүүр, доогуур, унах эрсдэлтэй, хангалтгүй г.м |
| Канад | 0-100 | 12 | A, B, C, D, F үсэг /A+, A, A- г.м/ | |
| Малайз | 0-4 | 11 | A, B, C, D, F үсэг /A, A- B+ г.м/ | Онц сайн, онц, маш сайн, сайн, боломжийн сайн, дунджаас сайн, дундаж, дунджаас доогуур, муу г.м |



## Үнэлгээний шинэчлэл хийх үндэслэл

**Үнэлгээний мөн чанар алдагдсан:** багш , суралцагчийг хянах, шалгах буюу “хариуцлага тооцох эсвэл дүн тавих хэрэгсэл” гэсэн хадлага давамгайлж байна.

**Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн үнэлгээ хангалтгүй:** үнэн зөв, бодит бус, шудрага бус, хийсвэр үнэлгээ давамгайлсан /дүнгийн хөөрөгдөл ихэссэн/

**Суралцагчдын дүнгийн 5 шатлал:** хэт ерөнхий, суралцагчдын ялгаатай байдал, түвшинг бодитой тодорхойлж чадахгүй байдал, 0-59 гэсэн интервал зохимжгүй, хүүхдийн сурах идэвхийг дэмжээгүй. /энд мэргэжлийн дүнг дүйцүүлэн анализ хийх/

**Шалгалт, судалгааны үр дүнгийн хэрэглээ, ашиглалт дутмаг, эргэх холбоогүй:** багш, сургуулийн үйл ажилагааг үнэлэхэд хэрэглэх байдал давамгай, сургалтын чанарыг сайжруулахад ашиглаж чадахгүй, боловсролын бодлогын хэрэгжилтийг тооцох, үнэлэх зэрэгт ашиглах, хэрэглэх байдал дутмаг.

Дээрх үндэслэлийг харгалзан БСШУС-ын сайдын 2018 оны 06 сарын 29-ны өдрийн А/425 тоот тушаал батлагдсанаар ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээ ОУ-ын түвшинд хүрсэн гэж үзэж болно.

“ЕБС-ийн суралцагч болон сургалтын чанарын үнэлгээний журам”

- Шалгуурт суурилсан үнэлгээ
- 8 түвшин, түүний шалгуур
- Үнэлгээний төрөл – Оношлох, – Явцын – Үр дүнгийн
- Үр дүнгийн үнэлгээ – Бүлэг сэдвийн – Хагас жилийн – Жилийн эцсийн – Анги дэвших шалгалт – Улсын шалгалт
- Дүн гаргах – Хагас жил – Жилийн эцэс – Шалгалт /анги дэвших болон улсын/
- Төлөвшил хандлагын үнэлгээ
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх эсэх
- Багшийн ажлыг үнэлж, дүгнэх журамтай уялдах байдал

## Суралцагчийн үнэлгээ




## Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

**Суралцагчийн хандлага төлөвшлийг үнэлэх:**

- Санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал
- Бие даан сурах арга барил,бусадтай хамтран ажиллах
- Шинжлэх судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо
- Соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар бүтээлч ажил хэрэгч байдал
- Хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт
- Шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт









## Суралцагчдын мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх

ХНХЯ-ны сайд, БСШУС-ын сайдын хамтарсан 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/506 А/266 дугаар тушаалын хэрэгжилтийг хангахад багш бүр дараах байдлыг харгалзан үзнэ.

## Үнэлгээний төрөл, ангилал

Суралцагчийг үнэлж, дүгнэх шалгуурыг тухайн хичээлийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх суурь, сонгох хэсгийн агуулгын хүрээнд боловсруулж, үнэлгээний төрөл, арга хэлбэрийг зөв оновчтой сонгоно.

Мэргэжлийн болон мэргэжлийн боловсрол олгох сругалтын мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн үнэлгээг чадамжаар /Чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй/, ерөнхий суурь хичээл, техникийн боловсрол олгох сургалтыг бүхэлд нь стандарт үнэлгээгээр үнэлнэ.

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлын түвшин, түүний ахиц өөрчлөлтийг сургалтын явцын, чадамжийн нэгжийн, улирлын, төгсөлтийн үнэлгээний төрлөөр үнэлнэ.

**“Явцын үнэлгээ”** гэж ээлжит хичээлийн үеэр суралцагчийн эзэмшиж буй мэдлэг, ур чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг тогтоох үйл явц

**“Чадамжийн нэгжийн үнэлгээ”** гэж тухайн чадамжийн нэгжийн хүрээний мэддлэг, ур чадвар, хандлагыг цогцоор нь эзэмшсэн эсэхийг тогтоох, баталгаажуулах үйл явц

**“Улирлын үнэлгээ”** гэж тухайн улиралд судалсан хичээлийн агуулгыг бүрэн эзэмшсэн эсэхийг тодорхойлох үйл явц

**“Төгсөлтийн үнэлгээ”** гэж тухайн мэргэжил, мэргэшилд хамаарах хичээлийн агуулгын хүрээг цогцоор нь эзэмшсэн эсэхийг төгсөлтийн явцад тогтоох, баталгаажуулах үйл явц

Техникийн боловсрол олгох сургалтад **явцын үнэлгээ, улирлын үнэлгээ, төгсөлтийн үнэлгээний** төрлийг хэрэгжүүлнэ.

Мэргэжлийн боловсрол олгох сургалтад **явцын үнэлгээ, чадамжийн нэгжийн үнэлгээ, төгсөлтийн үнэлгээний** төрлийг хэрэгжүүлнэ. /МБС-д 1жил, 2,5 жилийн сургалт багтана./

Мэргэжлийн сургалтад **явцын болон чадамжийн нэгжийн** үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд чадамжийн нэгжийн үнэлгээ нь төгсөлтийн үнэлгээ болно. /чадамжийн нэг болон хэд хэдэн нэгжийг судлахаас шалтгаалан хугацаа хамаарна/

### Онолын болон ур чадварын үнэлгээг дараах аргуудаас сонгон зохион байгуулна

Мэдлэгийг системтэй бүрэн эзэмшсэн байдлыг хяналтын ажил, тест, илтгэл, реферат, тайлан, төсөл бичих, тооцоолох, эссэ, зохиомж найруулан бичих, аялалын маршрут зохиох, ажиглах, тайлбарлах, ярилцлага, маргаан, мэтгэлцээн, хийх зэрэг аргаар онолын хэсгийг үнэлнэ.

Мэдлэгийг бүтээлчээр тодорхой нөхцөлд шилжүүлэн дадлагын ажил, сорил туршилт, үйлчилгээ, бүтээл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, даалгавар өгөх, төслийн ажил гүйцэтгүүлэх зэрэг аргаар ур чадварын хэсгийг үнэлнэ.

### Явцын үнэлгээний зохион байгуулалт

- Багш хичээлийн явцын үнэлгээг хийхдээ агуулгын аль нэг хэсэгт суралцагч мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшиж чадахгүй байгааг шинжлэн тогтоож, гүйцэтгэлийн хувиар тооцож, нотолгоог бүрдүүлнэ
- ЧЭ-ийг эзэмшүүлэх явцад болон төгсгөлд явцын үнэлгээг хийнэ. Элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэлд тохирсон ажилбарын хүрээнд мэргэжлийн багш ажлын даалгаврыг боловсруулна. Даалгаврын агуулгаас хамаарч үнэлгээний арга хэлбэрийг сонгоно.
- Явцын ур чадварын үнэлгээнд шаардлагатай материал, багаж хэрэгслийг хичээл заасан багш бэлтгэж, үнэлгээний орчныг бүрдүүлнэ

## ЧН-ийн үнэлгээний зохион байгуулалт

- Тухайн чадамжийн нэгжийг судалж дууссаны дараа нэгжийн үнэлгээг зохион байгуулна. ЧН-ийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд гүйцэтгэлд тохирсон ажилбарын ажлын даалгавар болон онолын мэдлэг үнэлэх үнэлгээний материалыг мэргэжлийн багш боловсруулж, сргалтын менежер хянаж, баталгаажуулна.
- Хөндлөнгийн үнэлгээний ажилтан оролцсон үнэлгээний баг чадамжийн нэгжийн үнэлгээг хийж, холбогдох тэнхим, арга зүйч, сургалтын менежер хяналт тавина.
- ЧН-ийн үнэлгээнд Хараахан чадамж эзэмшээгүй гэж үнэлэгдсэн суралцагчид агуулгыг бие даан нөхөж судлах боломж олгож, багш нар зөвлөн туслах төлөвлөгөөт хуваарийн дагуу суралцагчдад дэмжлэг үзүүлнэ.
- ЧН-ийн үнэлгээний онолын болон ур чадварын дүнг журналд гүйцэтгэлийн хувь, Чадамжтай, ХЧЭ гэсэн үнэгээгээр тэмдэглэж, улирлын дүн гаргах суурь нөхцлийг бүрдүүлнэ
- ЧН-ийн үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийн дагуу үнэлгээнд шаардлагатай түүхий эд, материал, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын тооцоог тухайн мэргэжлийн багш хийж, сургалтын байгууллага үнэлгээний орчныг бүрдүүлнэ.

## Улирлын үнэлгээ зохион байгуулах

Улирлын үнэлгээ нь техникийн болон МБС-ын стандарт хөтөлбөрт нийцсэн, тухайн улиралд үзсэн хичээлийн агуулгыг бүрэн хамарсан байна.

Улирлын үнэлгээг батлагдсан төлөвлөгөөний дагуу улирлын төгсгөлд зохион байгуулна. Сургалтын албанаас сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр улирлын шалгалтын хуваарийг гаргаж, бтаалгаажуулан 2-оос доошгүй долоо хоногийн өмнө багш, суралцагчдад мэдээлнэ.

Улирлын үнэлгээний багийг захирлын тушаалаар байгуулна

Улирлын үнэлгээний онолын мэдлэг шалгах материалыг сургалтын хөтөлбрт үндэслэн холбогдох тэнхмийн мэргэжлийн багш 4-өөс доошгүй хувилбартайгаар боловсруулна. Сургалтын алба тухайн хувилбараас сонгож, шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулна.

Үнэлгээний баг шалгалт эхлэхээс 1 хоногийн өмнө сонгосон шалгалтын материалын нууцлалыг алдагдуулахгүй хувилж, битүүмжилнэ

Үнэлгээ явагдаж эхлэхээс 15 минутын өмнө шалгагч багш үнэлгээний танхимд суралцагчдыг бүртгэж, суудал хуваарилан суулгаж, үнэлгээний дэгийг танилцуулан материалыг тараана

Улирлын үнэлгээний материалыг мэргэжлийн багш засч, дүнг тухайн өдөрт мэдээлнэ

Үнэлгээний багийн шийдвэрийн дагуу улирлын үнэлгээнд хүндэтгэх шалтгаанаар хамрагдаагүй болон хангалтгүй үнэлгээ авсан суралцагчийг 14 хоногийн дотор шалгалтын хуваарь гарган дахин үнэлгээнд хамруулна

Суралцагчийн улирлын үнэлгээний дүнг сургалтын алба баталгаажуулан мэдээллийн нэгдсэн системд оруулна

Улирлын үнэлгээний дүнд дүн-шинжилгээ хийх, тестийн сан бүрдүүлэх ажлыг сургалтын менежер, үнэлгээний баг хариуцан гүйцэтгэнэ

## Төгсөлтийн үнэлгээ зохион байгуулах

Төгсөлтийн үнэлгээ нь техникийн болон мэргэжлийн боловсрол, мрэгэжлийн сургалтын стандарт, хөтөлбөрт нийцсэн тухайн мэргэжлийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх суурь, сонгонсудлах хичээлийн агуулгыг бүрэн хамарсан байна.

Төгсөлтийн үнэлгээнд улирлын болон ЧН-ийн үнэлгээнд тэнцсэн, техникийн болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын стандарт, хөтөлбөрийн шаардлагыг хангасан суралцагч орно.

Төгсөлтийн үнэлгээний багийн бүрэлдэхүүн, удирдамжийг сургалтын байгууллага тухай бүр батлан удирдлага зохион байгуулалтаар хангана.

Үнэлгээний баг нь суралцгачдын даалгаврын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу ажиглах, нэмэлт асуулттавьж хариулт авах, гүйцэтгэлийн үр дүнд үзүүлэлт бүрээр үнэлгээ өгч дүнг нэгтгэнэ

Сургалтын менежер, үнэлгээний баг материалыг хүлээлцэх, задлах, хувилах, үнэлгээний дүнг нэгтгэн холблогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна

Үнэлгээний баг төгсөлтийн үнэлгээний явц, давуу болон сул тал, цаашид анхаарах асуудлын талаар дүгнэлт гаргана.

Мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа тохиолдолд бүх чадамжийн нэгж/хичээл-ийг эзэмшиж Чадамжтай/Хангалттай гэж үнэлэгдсэн тохиолдолд төгсөлтийн үнэлгээнд орох эрхтэй

ЧН эзэмшихээр суралцаж байгаа тохиолдолд ЧН-ийн үнэлгээ нь төгсөлтийн үнэлгээ байна.

Төгсөлтийн үнэлгээ нь хөндлөнгийн байж болох бөгөөд энэ тохиолдолд сургалтын байгууллага, МБСҮТ-тэй хамтран зохион байгуулна.

Үнэлгээнд дүн шинжилгээ хийх, тестийн сан бүрдүүлэх ажлыг МБСҮТ хариуцан гүйцэтгэнэ

Хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байгаа үед сургалтын байгууллага суралцагчийн суралцсан хугацааны мэдээлэл бусад нотлох баримтыг МБСҮТ-д тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлнэ

Мөн журамд заагдаагүй зохион байгуулалтыг шалгалтын болон үнэлгээний төлөвлөгөөнд зааж болно

Үнэлгээний зохион байгуулалтад гарсан санал гомдлыг дараах байдлаар шийдвэрлэнэ.

Суралцагчийн улирлын, ЧН-ийн голч дүнгийн талаар гаргасан маргааныг холбогдох тэнхмийн саналыг үндэслэн сургалтын алба шийдвэрлэнэ

Суралцагч төгсөлтийн үнэлгээтэй холбоотой санал, гомдлыг үнэлгээ зохион байгуулсан өдөрт багтаан тухайн сургуулийн үнэлгээний багт гаргана. Төгсөлтийн үнэлгээний талаар иргэд, багш, суралцагчийн гаргасан гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг үнэлгээний баг МБСҮТ-д хүргүүлэх ба үнэлгээний төв 5 хоногт багтаан арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

Санал гомдлын хариуг заасан хугацаанд багтаан мэдэгдэж, шийдвэрлэх үйл явц нь нээлттэй, ил тод, шудрага байна.

### Бидний дараагийн сэдэв

- Бүтээлч сэтгэлгээний аргат суралцахуй
- Ээлжит хичээлийн төлөвлөлтийг сайжруулах арга зүй
- Цахим сургалтын үр дүн
- Үнэлгээний төлөвлөгөө боловсруулах арга зүй.
- 2021.02-р сард хүрэх болно.

# ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ



# КУРСЫН АЖИЛ УДИРДАХ

Сургалтын арга зүйч И.Оюунчимэг



## Курсын ажлын зорилго

- Онолын мэдлэгийг бататгах, гүнгийрүүлэх, өргөтгөх
- Бие даасан үйл ажиллагааны дадал зүй эзэмшүүлэх
- Эргэцүүлэн бодох, дүгнэлт гаргах тэдгээрийг дэс дараалалтай, баталгаа нотолгоотой бичих чадвар суулгах
- Дипломын ажил бичих бэлтгэлтэй болох

## Удирдагч багшийн үүрэг

- Тэнхим мэргэжлийн чиглэл бүрээр курсын ажил удирдах багш нарын нэрсийг батлуулна.
- Удирдагч багш оюутанд онол арга зүйн зөвлөгөө өгөх, курсын ажлын агуулга бүтцийг батлах, судалгаа шинжилгээ хийхэд шаардагдах тоо мэдээлэл, хүснэгт маягтыг боловсруулахад туслах, ашиглах ном, сурах бичиг эх материалыг зааж өгөх, бичилтийн явцад хяналт тавих, батлсан график төлөвлөгөөний биелэлт өгсөн заавар зөвлөгөөний хэрэгжилтийг хянаж ажиллана.

## Оюутан, суралцагчийн үүрэг

Оюутан удирдагч болон сэдвээ сонгож, удирдагчийн зөвлөснөөр:

- Курсын ажил бичихэд шаардлага хангахуйц бодитой зөв тоо, мэдээ мэдээлэл цуглуулах
- Тоо, мэдээ мэдээллийг боловсруулах
- Судалгаа шинжилгээг онол арга зүйн түвшинд хийх
- Ном сурах бичиг унших товчлох
- Уншсан ном хийсэн судалгаа, шинжилгээгээ ашиглаж удирдагчийн батлсан төлөвлөгөө графикийн дагуу курсын ажлыг бичнэ. Бичиж дууссан курсын ажлын хавтсан дээр удирдагч
- гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэгч гарын үсэг зурснаар хамгаалалтанд орох эрх нээгдэнэ. Энэ журамд заасан үүргийг хангаагүй оюутныг хамгаалалтанд оруулахгүй.

## Курсын ажлын сэдэв сонгох баталгаажуулах

- Курсын ажлын сэдэв нь онолын хичээлийн зорилготой нийцсэн байна.
- Тэнхим курсын ажил бичих сэдвийн жагсаалтыг гаргаж сургалтын албаар баталгаажуулна.
- Батлсан сэдвүүдээс оюутан сонголт хийж удирдагч болон тэнхимд албан ёсоор бүртгүүлж сэдвээ баталгаажуулна.
- Баталгаажуулаагүй сэдвээр курсын ажил бичихийг хориглоно.

## Курсын ажлын хамгаалалт

- Сургалтын албанаас томилсон комисс тогтоосон хугацаанд оюутан бүрээр курсын ажлыг хамгаалуулж дүгнэнэ.
- Курсын ажилд үнэлэлт дүгнэлт өгөхдөө:
- Бүтээлийн онол арга зүйн түвшин
- Тавьсан зорилгоо шийдвэрлэсэн байдал
- Гарчиг агуулгын уялдаа холбоо, логик дараалал, эмх цэгц, бичилт
- Судалгаандаа ашигласан арга, мэдээ мэдээллийн бүрдүүлэлт, өнгө үзэмж, энэхүү журмыг дагаж мөрдсөн байдал зэргийг харгалзана.

## Курсын ажлын бүрдэл

- Нүүр хуудас (хуудас цаашид –х гэх)
- Гарчиг (1 х)
- Оршил (1-2 х)
- Сэдвийн үндсэн агуулга (20-25 х)
- Дүгнэлт санал (1-2 х)
- Ном зүй (1-2 х)
- Хавсралт (5-7 х)

Эдгээр бүрдэл хэсгүүдийн хуудсуудыг дугаарлах бөгөөд дэд гарчигт байгаа хүснэгт, график, диаграмм, бүдүүвчүүдийг тус тусад нь эхнээс нь өөрөөр хэлбэл 1-n хүртэл тоогоор дугаарлана. Тухайлбал хүснэгт №1 -15, график 1-12, диаграмм 1-8, бүдүүвч зураг 1-5 гэх мэтээр байх бөгөөд курсын ажилд нийт хичнээн хүснэгт, график, диаграмм, бүдүүвч зургаас бүрдэж байгааг шууд мэдэх боломж бүрдүүлнэ.

## Курсын ажлын бүтэц



1. Оршил
2. Онолын хэсэг
3. Судалгааны хэсэг
4. Дүгнэлт санал
5. Ном зүй
6. Хавсралт гэсэн бүтэцтэй байна.

## Оршил хэсэг

Уг сэдвийг сонгосон үндэслэл /хэрэгцээ шаардлага/ энэ талаар төр засгаас явуулж буй бодлого түүний хэрэгжилт, судалгааны зорилго, судалгааны обьектыг сонгосон үндэслэл болон тоо, мэдээ мэдээллийг олж бэлтгэх, боловсруулах, шинжилгээ хийхдээ ямар ямар арга ашигласан болон курсын ажлын бүтэц агуулгын тухай өгүүлнэ.

## Курсын ажил бичилтийн стандарт




Курсын ажлыг компьютерт үг үсгийн алдаагүй шивж, A4 цаасны нэг тал дээр хэвлэж хавтаслана. Хэмжээ нь 25-30 хуудас байна. Компьютерт шивэхдээ Arial эсвэл Times New Roman фондыг ашиглах бөгөөд хуудасны зүүн талд 3 см, баруун талд 1.5 см, дээд талд 2 см, доод талд 2.5 см зай үлдээж хөл толгой гаргаж, хөлд нь гүйцэтгэгчийн нэр, толгойд нь курсын ажлын сэдвийг бичнэ. Мөр хоорондын зай 1.5 ба үсгийн хэмжээ 12pt хэмжээтэй байна. Шинэ бүлэг бүр шинэ хуудаснаас эхэлнэ.

Энэ зарчмыг ажлын бүтэц болох оршил, дүгнэлт, ном зүйн жагсаалт, хавсралт зэрэгт адил хэрэглэнэ. Мөн ишлэл зүүлтийг зөв хэрэглэх хэрэгтэй.

## Курсын ажлын үндсэн агуулга

**I бүлэг буюу онолын хэсэг:** Сэдэвтэй холбоо бүхий онолын үзэл баримтлалуудыг харьцуулж, дүгнэлт өгч санал дэвшүүлнэ.

**II бүлэг буюу судалгааны хэсэг:** Математик, статистик, эконометрикийн аргуудыг ашиглаж хийсэн шинжилгээний үр дүнг хүснэгт, график, схемээр харуулж, үзэгдэл үйл явцын шалтгаан, үр дагавар, холбоо хамаарлын талаар товч тодорхой бичнэ.

**III бүлэг буюу судалгааны обьектын үйл ажиллагаар цаашид боловсронгуй болгох арга замын тухай хэсэг:** Судалгааны үндсэн дээр тодорхойлсон цаашдын төлөв, хандлага, зүй тогтлыг хураангуйлан тайлбарлана. Курсын ажлыг хоёр бүлэгтэй бичихээр төлөвлөвөл III бүлэгт бичих энэ санааг II бүлгийн төгсгөлд бичнэ.

**Дүгнэлт санал хэсэг:** I, II бүлгийн гол үр дүнг нэгтгэн товчоолно. Онолын үндэслэлтэй, практик ач холбогдолтой дүгнэлт хийж санал дэвшүүлэхийг шаардана. Ийм учраас дүгнэлт нь судалгаанаас үндэстэй, санал нь дүгнэлтээс гаралтай байвал зохино.

**Ном зүй гэсэн хэсэг:** Курсын ажил бичихэд ашигласан ном хэвлэл, бусад материалыг дотоод, гадаадаар нь ангилж, цагаан толгой үсгийн дараалаар зохиогчдын нэрсийг бүтээлийн нэр, хэвлэсэн он байгууллагын нэртэй хамт жагсааж бичнэ.

**Хавсралтад:** Курсын ажлын үндсэн агуулгыг тодруулсан туслах материалуудыг хавсаргана.

## ТЭМДЭГЛЭЛ



# БҮЛГИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

/Сургалтын арга зүйч Ц.Хулан /






## Мэдээлэл хүргэх арга дараалал

**Сургалтын агуулгын дагуу мэдээллийг логик дэс дараалаар тавихдаа:**

1. Сургалтанд тавигдсан зорилтын дагуу дараалалаар тавих
2. Энгийнээс хүндрүүлсэн дараалалтай явуулах
3. Аливаа сургалтын үйл ажиллагааг хийж эхлэхээсээ өмнө заавал тайлбарлаж өгч байх

**Мэдээллийг хэсэг хэсгээр танилцуулах**

- Сонирхолтой болгох
- Хэрэгтэй үед зарим газар түр зогсож, завсарлага хийж байх
- Хэрхэн ойлгосныг шалгах
- Гол үзэл санаа агуулга бүрийн дараа дүгнэлт хийж байх
- Суралцагчдад дадлага хийх боломжийг олгож байх



## Сургалтын үйл ажиллагааг жижиг хэсгүүдэд хуваах нь

**Дараах байдлаар хэсэгчлэн хуваана:**

- Хэрэглэгдэх үе шатууд
- Үе шатуудын дэс дараалал
- Үе шат бүрт хэрэглэгдэх гол санаа, агуулга
- Тус даалгаврыг гүйцэтгүүлэх хугацааг төлөвлөх
- Үе шат бүрт хэрэглэгдэх сургалтын материал, хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмж

## Сурах үйл ажиллагааны үр дүн

**SMART үр дүн**

- Specific -Тусгай
- Measurable -Хэмжиж болохуйц
- Achievable -Хүрэх үр дүн бүхий
- Realistic -Бодит
- Time Based -Бодит Цаг Хугацаа бүхий




Суралцагч юу, ямар мэдлэг олж авах талаар тодорхой бичиж тайлбарлах, тодорхой ойлголт өгөх

- Шинэ мэдлэг эзэмших
- Бодит ур чадвар
- Шинэ болон өөрчлөгдсөн хандлага арга ажиллагаа
- Эдгээрийн нэгдэл

## Сургалтын явц

- Үзүүлэн таниулах
- Тайлбарлах
- Зугуухан Үзүүлэн
- Дууриалгах
- Зааварлан, Дагалдуулан Давтуулах
- Хяналтын Ажил, Туршилт



## Хичээл сургалтыг явуулах

- Сургалт нь суралцагчдын анхаарал сонирхлыг татахуйц байх.
- Өмнөх дадлага туршлагатай холбогдох
- Хичээлээс гарах үр дүн
- Сургалтын Бүтэц
- Суралцагчдыг Идэвхжүүлэх

## Сургалт

- Онолын Сургалт – шинэ мэдээлэл
- Сургалтыг явуулах арга ажиллагаа – мэдээллийг ашиглах, хэрэглэх
- Дүгнэлт – мэдээллийг нэгтгэн дүгнэх




## Хичээлийн дүгнэлт

- Үр Дүн
- Санал Дүгнэлт
- Цаашдын Зорилт

## Шинээр эзэмшсэн ур чадвараа дадлага болгож ашиглах боломж

- Хамт олноороо санал бодлоо уралдуулах
- Мэтгэлцэх
- Тайлан амаар тавих
- Хяналтын ажил
- Дүрд тоглуулах
- Асуултууд тавих
- Бичгээр тайлан тавих



## Бүлгийн Хөдөлгөгч Хүч



- Бүлэг Үүсгэх
- Маргалдах
- Хэм Хэмжээг бий болгох
- Гүйцэтгэл
- Хугацаа Сунгах

Хэрвээ бүлгийн хөдөлгөгч хүч сайн байвал бүлгээр суралцах, бүлгээр ажиллах арга хамгийн сайн суралцах хэрэгслэл болдог.

## Бүлгээр сургах сургалтын арга

Бүлгээр сургах арга нь суралцагчид нэг нэгнээсээ суралцах давуу талтай.

Бүлгээр сургах арга нь суралцагчдыг хоорондоо ярилцангаа суралцах боломжийг олгодог нь мэдээллийг боловсруулах хамгийн сайн арга болдог.

Мэдлэг туршлагаа хоорондоо хуваалцах боломжийг бүрдүүлдэг

Нийгэм хамт олны дунд байж, нийгмийн харилцаанаас сэтгэл ханамжийг хүртдэг

## Боломж, чадал, хүсэл сонирхол



Боломж Бололцоо, Чадал

- Мэдлэг
- Ур Чадвар
- Дадлага Туршлага

Чадал,Хүсэл Сонирхол

- Итгэл Үнэмшил
- Идэвх Зүтгэл
- Үүрэг Хариуцлага

## Бүлэг хамт олноор нь сургахын давуу тал

Бүлгийн гишүүд нь нэг нэгнийхээ талаар сайн болон сөрөг сэтгэгдлийг олж авна.

Далд үлдсэн мэдээлэл асуудлуудыг харж чаддаг болно.

Бүлгээр сургахад нэг хүн сургалтын бүх даалгавар ажлыг гүйцэтгэхгүй бүлэг хамт олноороо ажиллах давуу талтай.

Бүлгээр сургах сургалтын явцад ажигч байх, суралцах явцад гарч буй өөрчлөлтийг анзаардаг болно.

## Бүлгийн хэлэлцүүлэгийг удирдан чиглүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, даалгаврыг тодорхой болгох

Хүрэх үр дүн болон тухайн асуудалд хандуулан ажиллуулах хоёрыг жигд тэнцвэртэй явуулах

Бодит болон бодит бус байдлын хоорондын ялгаа заагийг ялгаж салгаж байх

Тээнэгэлзсэн эргэлзсэн байдлыг арилгаж байх

Бүлгийг мухардмал байдлаас гаргах

Бүх оролцогчдыг хөхүүлэн дэмжиж байх

## Хүмүүсийн хандлагыг өөрчлөх арга




### Хэцүү суралцагсадтай хэрхэн ажиллах вэ?

- Өөртөө итгэлтэй байвал суралцагсад таныг хүндэлдэг болно.
- Хичээлийн бэлтгэлээ сайн хангаж бай!
- Тодорхой ойлгомжтой харилцаж байх.
- Хэт хатуу бүү ханд, эелдэг бай!
- Зоригтой бай !
- Суралцагчдын биеэ хэрхэн авч яваа байдалд хэт анхаарал бүү тавь.
- (Хичнээн өөрөө хүсч байсан ч) алиа хошин зан байнга бүү гарга.

### Зөрчилдөөн болон бодит байдал

Бодит Байдалд хүмүүс хоорондоо муудалцахаараа:

- Бүлгээсээ гардаг хоорондоо ярилцахаа больдог, хүйтэн хөндий харилцаа үүсч нэг нь нөгөөдөө дургүй болдог.

Эдгээр мэдрэмжүүдийг дарах

- Юу ч болоогүй мэт бай, хурцадмал байдлыг үл тоо, аль болох намжмал байдлыг бий болго.

Өрсөлдөөн

- Муухай аашлах, ар хударгаар хутга шаах, хашгарах, биенд халдах, асуудлыг төөрөгдүүлэх,дүрэм журмыг гуйвуулах, бусдыг лоббидох



## Сургалтын үеэр гарах зөрчлийг зохицуулах

Юу болоод байгааг олж тогтоох
Яаж зохицуулах талаар бодох
Эв зүйгээр зохицуулж болох эсэх?
Аль алинд нь харилцан буулт хийх хандлага



## Сайн харилцааг сааруулах саад

- Энгийн зүйлийг хэлэхийн оронд урт урт үгүүдийг хэрэглэх
- Хар яриа болон товчилсон үг хэрэглэх
- Нутаг нугын ялгаа гаргах
- Нэгэн хэвийн, уйтгартай лекц
- Төдийлэн тустай биш сургалтын хэрэглэгдэхүүн
- Нэр томъёоны буруу ойлголт
- Нэг нэгнийгээ урьдчилан ойлголцсон байх
- Үндсэн ойлголттой болсон байх

## Суралцагчдад хариулт өгөхдөө

- Сургалт явуулж байхдаа, нүд болон үгээр харьцаж,толгой дохиж, инээмсэглэж байх.
- Ихэнхи тохиолдолд эерэг хариулт өгч байх.
- Өөрийгөө хүндлэх байдлыг нэмэгдүүлэх

3 хариулт :

Өөрчлөн найруулан хэлэх
Эргэцүүлэн бодож хэлэх
Урамшуулан зоригжуулж хэлэх

## Үр дүнтэй харилцаа

Сургалтын явцад суралцагчид болон сургагч багшийн хооронд үр дүнтэй харилцаа маш чухал

## Биеийн хэлээр харьцах

1. Ямар дохио зангаагаар ярилцахаа мэддэг байх
2. Өөр бодитой саад болох ямар зүйлс байж болох вэ?
3. Ямар дохио зангааны хэл ашиглаж болох вэ?



## Асуулт тавих арга техник

- Нээлттэй Асуулт- Бодох, шүүн тунгаах, хэлэлцэхийг дэмжсэн асуултууд
- Хаалттай Асуулт- баримт мэдээллийг шалгах, тусгай мэдээлэл олж авах
- Туршилтын Асуултууд- Бүлэг болон хувь хүнээс илүү мэдээлэл олж авах
- Шууд Асуулт – тухайлсан нэг хүнд зориулагдсан, ойголтыг шалгах (нээлттэй ба хаалттай асуултууд)
- Шууд Бус Асуултууд- Бүлгийн ойлгоцыг шалгах бүлэгт зориулсан (нээлттэй ба хаалттай асуултууд)

## Суралцагчдын идэвхийг бий болгох нь

- Оролцооны Түвшин
- Ирц болон оролцооны түвшин
- Урам хугарах, анхаарал сарних, сэтгэл зовнил
  - Амархнаас хүндрүүлэх арга
  - Хамаарах түвшин
  - Сургалтын зогсонги байдал



## Санал зөвлөмж өгөх

- Санал зөвлөмжөө яаж өгөхөө мэддэг байх
- Ихэвчлэн амаар санал зөвлөмжөө өгч байх ч бичгийн ажилд бичгээр өгөх
- ингэхдээ дараах зүйлүүдийг анхаарч байх:
- Шүүх биш сайшаан урамшуулж байх
- Үнэнч шударга мэдрэмжтэй байх
- Хүнийг нь биш, үйлдлийг нь дүгнэж цэгнэх
- Нууцлалыг хадгалдаг байх
- “KISS” Маш Энгийн Байлгах зарчим баримтлах
- Хэр зэрэг ойлгосныг нь шалгах
- “Hamburger” санал зөвлөмж. Суралцагчдын зөв, буруу хийснийг ярилцсаны үндсэн дээр хавчууртай талх мэт сайн, муу, сайн гэсэн дараалаар санал зөвлөмж өгөх.

## Үр дүнтэй сонсох арга



1. Бүх анхаарлаа хандуулж сонс.
   - Үгээр болон дохиогоор
2. Санал Зөвлөмж өгөх.
   - Тэдний хэлж байгаа санааг нь ойлгосон гэдгээ харуул.
3. Далд утгыг сайн ойлгож сонс.
   - Яг юу хэлээд байгааг нь сонс.
4. Санаа зовж байгаагаа харуул
   - Хичнээн санал нийлэхгүй байсан ч гэсэн үзэл бодлыг ойлгохыг хичээ

## Үр дүнтэй сонсоход саад болдог зүйлүүд



1. Тасалдуулах
   - Хүн бүрийг хэлж буй зүйлээ дуустал нь хэлүүлж байх.
2. Сэтгэл Хөдлөл
Сургалт бол нэг талаас, оюуны үйлдвэрлэлийн зохион байгуулалт, нөгөө талаас оролцогчдын /багш, суралцагчдын/ мэдлэг, дадлага, хандлагын өөрчлөлтийн үйл явц учраас **"сургалтын менежмент"** бол нэг талдаа **"байгууллагын менежмент"**-ийн нөгөө талдаа **"өөрчлөлтийн менежмент"**- ийн онцлог бүх шинжийг агуулна

Сургалтын менежмент гэсэн ерөнхий ухагдахуун нь дараах түвшин, шатлалтайгаар нийгмийн практикт хэрэгжинэ.

- Сургалтын байгууллагын менежмент
- Сургалтын менежмент
- Сургалтын технологийн менежмент

## Сургалтын удирдлагын арга, зохион байгуулалт

Менежмент бол эцсийн үр дүндээ тодорхой зорилгод хүрэх удирдлагын арга барилын хөгжлийн ухаан, арга технологио тасралтгүй сайжруулах урлаг.Тухайлбал,

- **Аргачлал (алгоритм)-** тодорхой асуудлыг шинжлэх судлах дэс дараалсан логик алхамууд(үйлдлийн түвшинд боловсруулсан тогтолцоо);
- **Арга-** маш тодорхой үед харьцангуй тогтвортой нөхцөлд тодорхой зорилгоор ашиглах бүтэц, зохион байгуулалт, стратеги гэх мэт хэрэгсэл;
- **Аргазүй-** тодорхой нөхцөлд, зорилгод(зорилтод)нийцүүлэн аливаа үйл, үйлдэл хийх , үйл ажиллагаа хэрэгжүүлэх багц арга, аргуудын хослол
- **Арга судлал-** багц аргаас оновчтойг сонгох, эсвэл тодорхой аргуудыг хөгжүүлэх, боловсронгуй болгох онол, шинжлэх ухаан.

Зорилгоо хамгийн оновчтой тодорхойлж, зорилгодоо хамгийн бага зардлаар хүрч, үр ашигтай-шинэ-чанартай-үр дүн гаргах шинжлэх ухаанч ур чадвар бол үндсэндээ менежментийн мөн чанар юм. Ингэхийнтулднөөцүүдээбодожболовсруулан хамгийн оновчтой байршуулах, гүйцэтгэлийн арга барилаа байнга сайжруулах хандлагын шалгуур гэмээр ажлын бүтэцчилсэн хүрээг менежментийн “7S” стратеги – зарчим гэж байна. Үүнд:

**System-** Тогтолцоо
**Structure- Бүтэц**
**Strategy-** Стратеги
**Skill-**Ур Чадвар
**Staffing-** Хүний нөөцийн хөгжил, хангамж
**Style-** Арга барил
**Super goal (Shared values)-** Дээд зорилго(Хамтын үнэт зүйлс)

Эдгээрийн аль нэг хэсэгт дутагдал, засаж сайжруулах зүйл байвал түүнийг боловсронгуй болгох **АРГА ТЕХНОЛОГИЙГ** олж хэрэгжүүлэх хэрэгтэй.




Үйлдвэрлэлийн сургалтын систем нь тухайн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээндэх түгээмэл **ажлын арга барил, үйлдэл, иж бүрдэл үйлдэл,хөдөлмөрийн үйл ажиллагаа, ажлын төрлүүдийг** тодорхой дэс дараалалаар хамгийн оновчтой, үр ашигтай эзэмшүүлэх нөхцөлийг хангахуйц сургалтын агуулга, арга хэлбэр, дидактик хэрэгсэлийн бодит нэгдэл гэж үзэж болно.

## Мэргэжлийн чадвар, дадлын ¿ндсэн ò°ðл¿¿д

**Хөдөлгөөний дадал.** Хөдөлмөрийн аливаа нарийвчлал, хурд, хүч, зохицуулалтыг хангаж зөв гүйцэтгэхэд бэлэн байх явдал юм.

**Оюун ухааны дадал.** Техникийн баримт бичгүүдийг судлах, үйлдвэрлэлийн үйл явцыг төлөвлөх янз бүрийн чадварт сэтгэцийн процесс болон тусгайлан бодож боловсруулалгүй хэрэгдэх стандартчлагдах тийм оюуны үйл ажиллагааны элементүүдэд голлох үүрэгтэй.

**Мэдрэхүйн дадал.** Үйлдвэрлэлийн үйл явцыг хянах, бэлтгэх, үйлчлэхтэй холбогдсон ур чадваруудыг эзэмшихэд мэдэрхүйн дадлууд маш чухал шаардлагатай.

## Үйлдвэрлэл сургалтыг амжилттай хэрэгжүүлэх нь




Хөдөлмөрийн процесс, хөдөлмөрийн багаж түүнийг хэрэглэхдээ хүртэж ухамсарлах процесст шинжлэх ухааны анализын аргыг ашиглах, үйлдвэрлэлийн орчинд хэрэглэх аргыг суралцагчдад эзэмшүүлэх хэрэгтэй. Сурагчдад янз бүрийн материал, үйл явцыг ойлгуулахад индуктив, дидуктив, анализ-синтезийн аргыг өргөн хэрэглэх ёстой.

**Индуктив-**(нэгтгэн дүгнэх) тодорхой үзэгдэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ерөнхий шинж чанар, шаардлагыг тодорхойлж нэгтгэн дүгнэх арга юм.

**Дидуктив-**(задлан ялгах) ерөнхий үзэгдэлтэй танилцаж түүнээс тодорхой үзэгдэл юмс, зарчмуудыг илрүүлэн гаргах арга юм.

**Анализ-синтез-**(задлан шинжилгээ, нэгтгэн дүгнэх) тодорхой үзэгдэл, объект, зарчмуудад задлан шинжлэх нэгтгэн дүгнэх үйлийн үндсэн дээр аажмаар ойлголт, шаардлага, нөхцлийг тодорхойлох арга юм. Үйлдвэрлэлийн сургалтын үед (техникийн объект, технологийн процесс, хөдөлмөрийн процесс, хөдөлмөрийн багаж зэвсэг, түүнийг хэрэглэх арга, хяналт хэмжүүрийн багажуудыг) хүртэж мэдэхэд мэдээлэл дамжуулах бүх аргыг хослуулан хэрэглэнэ.

## МЭРГЭЖЛИЙН ДАДЛАГА

Суралцагчдад чадвар, дадал, нарийн ур чадвар эзэмшүүлэх дасгалын бүхэл бүтэн систем боловсруулах шаардлагатай болно. Дасгал нь дараах ерөнхий шаардлагуудыг хангасан байх ёстой.

А. Дасгал нь хийж хэрэгжүүлэх тодорхой системтэй байна.

Б. Дасгалын агуулга, арга нь цаашлах тутам хүндэрч нарийсч байна.

В. Дасгалын гүйцэтгэл нь сургалтын тодорхой үе шатаар хийгдэх боловч энэ нь цорын ганц чиглэл биш бөгөөд бутээгдэхүүн үйлдвэрлэх буюу материалын үнэт зүйлсийг бий болгох үе шатаар бас хэрэгжинэ.

Г.Дасгалын агуулга түүнийг гүйцэтгэх арга нь суралцагчийн эзэмшиж буй мэргэжлийн хөдөлмөрийн онцлогийг тусгасан байх болно.

Д.Бие даан гүйцэтгүүлэх

Е.Хянах, сайжруулах




# ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАР



## Хатуу ур чадвар

Хатуу ур чадвар гэдэг нь тоогоор тодорхойлоход хялбар заах чадвар эсвэл ур чадварын багц юм. Ихэвчлэн та анги дээр, ном эсвэл бусад сургалтын материалаар дамжуулан, эсвэл ажлын байран дээрээс хүнд ур чадвар эзэмших болно. Эдгээр хатуу ур чадварыг ихэвчлэн таны захидал , намтар дээр бичдэг бөгөөд ажил олгогч эсвэл ажилд зуучлагч танихад хялбар байдаг.

**Хатуу ур чадварт дараахь зүйлс орно.**

Гадаад хэлний мэдлэгтэй
Цол, Диплом
Бичгийн чадвар
Техник хэрэгсэлтэй ажиллах
Компьютерийн програмчлал

## Зөөлөн ур чадвар

Нөгөө талаас зөөлөн ур чадвар гэдэг нь тоогоор илэрхийлэхэд илүү хэцүү субъектив чадвар юм. "Хүмүүсийн ур чадвар" эсвэл " хүнтэй харьцах чадвар" гэж нэрлэдэг бөгөөд зөөлөн ур чадвар нь бусад хүмүүстэй харьцах, харьцах байдалтай холбоотой байдаг.

**Зөөлөн ур чадвард дараахь зүйлс орно.**

Харилцаа холбоо
Уян хатан байдал
Манлайлал
Хүсэл эрмэлзэл
Тэвчээр
Ятгах
Асуудлыг шийдвэрлэх чадвар
Багаар ажиллах
Цаг төлөвлөлт
Бүтээлч сэтгэлгээ



**92%**
Зөөлөн ур чадвар мэргэжлийн ур чадвараас чухал гэж хэлж буй хүмүүс

**Ажилд авахдаа чухалчилж буй зүйлс:**

**30%**
Зөөлөн ур чадвар
**62%**
Зөөлөн болон мэргэжлийн ур чадвар
**8%**
Мэргэжлийн ур чадвар

**Буруу хүнд байдаг шинжүүд**



**45%**
Зөөлөн ур чадвар
**44%**
Зөөлөн болон мэргэжлийн ур чадвар
**11%**
Мэргэжлийн ур чадвар

**89%**
Буруу хүн гэж зөөлөн ур чадваргүй хүнийг хэлнэ гэж буй хүмүүс



# ТЭМДЭГЛЭЛ

БОЛОВСРОЛЫН
БАЙГУУЛЛАГА



# БОЛОВСРОЛЫН МАРКЕТИНГ

/МТАЖ тэнхимийн эрхлэгч Б.Анхбаяр/



БИЗНЕСИЙН
БАЙГУУЛЛАГА

01 ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

САНХҮҮГИЙН УДИРДЛАГА 02

03 МАРКЕТИНГИЙН УДИРДЛАГА

- Байгууллагын хамгийн чухал хөрөнгө оруулалт бол Хүний нөөцийн бодлого юм.
- Байгууллагын тогтвортой үйл ажиллагаар мөнгө санхүүгийн бодлогоор зохицуулдаг
- Зах зээл дээрхи эрэлт нийлүүлэлтийг маркетингийн удирдлагаар зохицуулдаг

## БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГЫН МАРКЕТИНГИЙН ИЖ БҮРДЭЛ

| ХЭРЭГЛЭГЧ | БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ | ОРЧИН | ҮЙЛ АЖИЛЛАГАА | ҮНЭ БҮРДЭЛТ | ХУВИАРЛАЛТ | ИДЭВХИЖҮҮЛЭЛТ |
|---|---|---|---|---|---|---|
| Хэрэглэгч юу хүсч байна вэ? | Ямар үйлчилгээ тохиромжтой вэ? | Ямар орчин тохиромжтой вэ? | Үндсэн+ нэмэлт үйлчилгээ | Үнэ хэд байх вэ? | Хаана хэнд үзүүлэх вэ? | Хэрхэн олон үйлчлүүлэгчийг татах вэ? |

# БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ

**Боловсрол хэмээх оюуны үйлчилгээний** бие хүн болон нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүргийг томьёолбол:

**Хүнийг зөв төлөвшүүлэх**

Биехүнийгоюунухааны зохих чадавхитай, эрүүл чийрэг бие бялдартай, ёс суртахууны болоод гоо зүйн өндөр соёлтой, бие даан амьдарч, сурч хөдөлмөрлөх чадвартай иргэн болгон төлөвшүүлдэг.

**Эдийн засгийн өсөлтийг бий болгох**

Улс орны хөгжил, дэвшлийг хурдасгадаг. Нөгөө талаар боловсролын үйлчилгээ нь эргээд эдийн засгийн өсөлтийн нэг хүчин зүйл болдог.

**Үндэсний аюулгүй байдлыг хангах**

Улс орны эдийн засаг, улс төр, тусгаар тогтнол аюулгүй байдлын баталгаа болж байдаг.

## БОЛОВСРОЛЫН МАРКЕТИНГИЙН ИЖ БҮРДЭЛ

| ХЭРЭГЛЭГЧ | БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ | ОРЧИН | ҮЙЛ АЖИЛЛАГАА | ҮНЭ БҮРДЭЛТ | ХУВИАРЛАЛТ | ИДЭВХИЖҮҮЛЭЛТ |
|---|---|---|---|---|---|---|
| ЭЛСЭГЧИД, АЖИЛ ОЛГОГЧИД | СУРГАЛТЫН ҮР ДҮН- ТӨГСӨГЧИД | СУРГАЛТЫН ОРЧИН | СУРГАЛТ +БАГШ НАР | СУРГАЛТЫН ТӨЛБӨР= САНХҮҮЖИЛТ | АЖИЛД ЗУУЧЛАЛ | ЭЛСЭЛТ+СУРГАЛТ +ТӨГСӨЛТ |

## МБС-ын байгууллагын хэрэглэгч хэн вэ?



# МАНАЙ СУРГУУЛЬД ЭЛСЭХЭЭР ХЭН ХАМГИЙН ИХЭЭР ЭЛСЭХИЙГ ХҮСЭХ ВЭ?

**Карьераа эхлэгсэд –** Карьертаа илүү анхаарч, ирээдүйн ажил мэргэжилдээ төлөвлөсөн суралцагчид



## RESEARCH



**Сурах сонирхолтой –** Ихэвчлэн 18-24 насны сурлага, дүн сайтай суралцагчид

## MARKETING

**Салбар солигчид**

**Сургууль хэсэгчид –** Тэд бол нэлээн хожуу коллежид сурсан, яг тодорхойлсон чиглэл байхгүй боловч боловсроалын бичиг баримттай болсноор ямар нэг боломж, үүд хаалга нээгдэнэ гэж итгэгчид.

## SUCCESS



**Цаг нь болсон** – Сурах ёстой, нас нь болсон. гэхдээ яг юу сурахаа шийдэж амжаагүй хүмүүс



## БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АМЬДРАЛЫН МӨЧЛӨГ




- ЭЛСЭГЧ БАГА
- АЖИЛ ОЛГОГЧДЫН ЭРЭЛТ ҮҮСЧ ЭХЭЛНЭ

- ЭЛСЭГЧ ИХЭСНЭ
- АЖИЛ ОЛГОГЧ АЖИЛТНЫ ТӨЛӨӨ ӨРСӨЛДӨНӨ

- ЭЛСЭГЧ БУУРНА
- АЖИЛ ОЛГОГЧ АЖИЛТНЫГ ОРЛОХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР СОЛИХ

- ЭЛСЭГЧ БАЙХГҮЙ
- ДАМ ПУУРЛЫН ШАТ ҮҮСНЭ.

## МБС-ЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЭГДЭХҮҮН ЮУ БАЙХ ВЭ?

Life is Good

**СУРГАЛТ**
/Танхимын болон цахим, үйлдвэрлэлийн /

**ХАНДЛАГА**
/сэтгэл зүйн боловсрол/

**ИРГЭНИЙ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХ ЧАДВАРТ СУРГАХ /эрүүл байх, аюулгүй байх, эх орноо хамгаалах/**

**АМЬДРАХ УР ЧАДВАРТ СУРГАХ / бие даан амьдрах, сурах, хөдөлмөрлөх/**

**ИРГЭН, ӨРХ ГЭР**

**АЖИЛ ОЛГОГЧИД**

**ТӨР, ЗАСАГ**



# БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХУВААРИЛАЛТ...

| БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГА -100% | БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА - ? |
|---|---|
| БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ | ТӨГСӨГЧДИЙГ АЖЛЫН БАЙРАНД ЗУУЧЛАХ |



- БӨӨНИЙ ТӨВ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА
- ОНЛАЙН ХУДАЛДАА
- БОРЛУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- НЭРИЙН ДЭЛГҮҮР, ӨӨРИЙН АЖЛЫН БАЙР

- АЖИЛ ОЛГОГЧИД
- ХӨДӨЛМӨР БИРЖ
- ӨӨРӨӨ ӨӨРТӨӨ АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ

БОРЛУУЛАЛТ -100% → АШИГ → АЖИЛЧИД ЦАЛИН → ТОГТВОРТОЙ ОРЛОГО

# БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ПРОЦЕСС

ОРЦ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

ҮЙЛДВЭРЛЭЛ

ГАРЦ

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ЭЛСЭГЧ
АЖИЛ ОЛГОГЧ

СУРГАЛТ

ТӨГСӨЛТ = АЖИЛ
ЭРХЛЭЛТ
АМЬДРАЛЫН БАТАЛГАА

ИДЭВХЖҮҮЛЭЛТ....

ҮЙЛДВЭРЛЭЛ

ГАРЦ

ОРЦ

БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦ

ТӨГСӨЛТ = АЖИЛ ЭРХЛЭЛТ АМЬДРАЛЫН БАТАЛГАА
/ ИДЭВХЖҮҮЛЭЛТ -0%

ЭЛСЭГЧ - 70%
АЖИЛ ОЛГОГЧ -0%

СУРГАЛТ
30%

ЭЛСЭЛТ 20% → СУРГАЛТ 60% → ТӨГСӨЛТ 20%

# БАГШ, АЖИЛТНЫ ХАНДЛАГА – СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРТАЛЧИЛГАА БОЛДОГ УУ?

**БАГШ, АЖИЛТНЫ АЖИЛДАА ХАНДАХ ХАНДЛАГА**




**БАГШ ТАНЫ ҮЙЛДЭЛ ӨДӨР БҮР 1000 СУРАЛЦАГЧДААР ДАМЖИН СУРГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА БОЛЖ БАЙДАГ. ЭНЭХҮҮ СУРТАЛЧИЛГАА НЬ АЛБАН ЁСООР ЗОРЬЖ ХИЙСЭН СУРТАЛЧИЛГААНААС ИЛҮҮ ҮР НӨЛӨӨТЭЙ.**

# I ГУРВАН ЦОГЦ ЧАДАМЖ БА ТҮҮНИЙ ГУРВАН ТҮВШИН




*”НИЙГМИЙН ХАРИЛЦАА, СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, ЁС ЗҮЙД СУРАЛЦАХУЙ”, БАГШИЙН НОМ




***Зураг 2.*** Түвшин болон цогц чадамжийн есөн бүрэлдэхүүн хэсгүүд. НХСХЁЗ сургалтын гурван цогц чадамж, гурван түвшинг есөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх матрицад байрлуулсан байдал.

# БИД ХӨГЖЛИЙГ ТҮҮЧЭЭЛНЭ.






1. БУСАД СУРГУУЛИАС ЯЛГАРСАН ХҮЧТЭЙ БРЭНДИНГ БИЙ БОЛГОХ
2. ХЭРЭГЛЭГЧИЙН ХҮСЭЛТЭД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГШ АЖИЛТАН БҮХИЙ Л ҮЙЛ ЯВЦАД СУРАЛЦАГЧДЫГ ҮЛГЭРЛЭХ
3. МЭРГЭЖЛИЙН НЭР ХҮНД ӨСГӨХ ЗАМААР САНХҮҮГИЙН ЭРСДЛЭЭС ГАРАХ ШИНЭЛЭГ ИННОВАЦИ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ
4. ГАДААД ХАРИЛЦААНЫ ТҮВШИН БА ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ
5. АМЖИЛТТАЙ ТӨГСӨГЧДӨӨ ЗАРЛАХ / БОРЛУУЛАХ/

- СУРАЛЦАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ
- ЭЦЭГ ЭХИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ
- ТӨГСӨГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ
- АЖИЛ ОЛГОГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ



## БОЛОВСРОЛЫН МАРКЕТИНГИЙГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

- ПРОЦЕССИЙН ҮЕ ШАТ БҮР ДЭХ СУРТАЛЧИЛГААГ АНХААРАХ
- БОЛОВСРОЛЫН МАРКЕТИНГИЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙГ БИЙ БОЛГОХ
- МАРКЕТИНГИЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦЫГ БҮРДҮҮЛЭХ
- БАГШ АЖИЛТНУУД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ, ХҮРСЭН ҮР ДҮНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ТОГТМОЛ ХИЙХ
- УРАМШУУЛЛЫН НЭМЭЛТ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ
- БҮТЭЭГДЭХҮҮН, ДАГАЛДАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ АНХААРАХ

# ТЭМДЭГЛЭЛ



# ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН СЭТГЭЛ ЗҮЙ

/Нийгмийн ажилтан В.Гэрэлцэцэг/







## ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ГЭЖ ЮУ ВЭ?

- ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ГЭДЭГ НЬ БИЕ, ОЮУН УХААН, СЭТГЭЦ, МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ БОЛОН БИЕЭ АВЧ ЯВАХ БАЙДАЛ, АЛИВАА ЮМС ҮЗЭГДЭЛД ХАНДАХ ХАРЬЦАА ХАНДЛАГА НЭГ ТҮВШНЭЭС ДАДЛАГЫН ДЭЭД ШАТ РУУ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ЧАНАРЫН ӨӨРЧЛӨЛТ ГАРАХ ҮЙЛ ЯВЦ

## ХҮҮХДИЙН ТӨЛӨВШИЛ ГЭЖ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

- ХҮҮХДИЙН ТӨЛӨВШИЛ ГЭДЭГ НЬ ДЭЭРХ ХӨГЖЛИЙН ҮР ДҮНД АМЬДРАЛЫН БҮХИЙ Л ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ОЛЖ АВСАН МЭДЛЭГ ,ЧАДВАР ,ДАДАЛ, АМЬДРАЛЫН ТУРШЛАГА ,БИЕ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ЦАР ХҮРЭЭ ДҮВШИН ЕРӨНХИЙ СОЁЛЫН БҮРЭЛДЭХҮҮН ЮМ.

- ХҮНИЙГ ХҮМҮҮЖҮҮЛЖ ТӨЛӨВШҮҮЛНЭ ГЭДЭГ НЬ НЭГ ТАЛААС ҮЗВЭЛ ХҮНИЙ ДУТАГДАЛД ЗӨВ ХАНДАХ ЯВДАЛ ЮМ. ЕР НЬ ХҮНИЙ ДУТАГДЛЫГ ХЭЛЭХ ОЙЛГУУЛАХ ТҮҮНИЙГ ДАХИН ДАВТУУЛАХГҮЙГЭЭР ЗАСАЖ, ЗАЛРУУЛДАГ ХЭВШИЛТЭЙ БОЛГОХ

## ХЭРВЭЭ ХҮҮХЭД




Гэж буддын гүн ухаанд сургасан байдаг.



# ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН НАСНЫ АНГИЛАЛ



- **10-12 нас эрт үе**
- **13-15 нас дунд үе**
- **16-17 нас хожуу үе**

### 15 настай хүүхдийн онцлог

- Хийсвэрлэн сэтгэх, үр дүнг харах, сэтгэн бодох чадвартай болно
- Бие бялдрын имиж шинэчлэгдэнэ. Хийсвэрлэх сэтгэлгээ тогтсон, хүч чадлын тухай ойлголттой болно
- Хэт их хяналт, анхаарал, халамж зөрчигдөнө
- Өөрийн гэсэн дүр төрхөө тодорхойлох хэрэгцээ бий болно
- Үе тэнгийнхний бүлэглэлүүд өөрсдийн зан үйлийнхээ хэв маягийг тодорхойлно
- Сэтгэл хөдлөлд автана. Эсрэг хүйсийн хэн нэгний анхаарлыг татаж байгаа эсэхээ мэдрэх чадвар бүрдэнэ

### Өсвөр насны хүүхдийн онцлог

- Өсвөр насанд охидууд хөвгүүдээс олон талаар илүү түргэн хөгждөг. Үүнээс гадна хувь хүн тус бүрийн сэтгэцийн хөгжил харьцангүй биш явагдаж, сэтгэцийн зарим тал илүү түргэн хөгжиж байхад зарим нь харьцангүй удаан хөгжиж байдаг.
- Өсвөр насныхны шинэ бүрдэл шинж бол охид, хөвгүүдэд өөрсдийгөө “насанд хүрсэн том хүн болсон” хэмээн мэдэрч өөрсдийг нь “том хүн” гэж хүлээж авахыг хүрээлж буй хүмүүсээс шаарддаг.

## ЭНЭ НАСНЫ МЭДРЭМЖ





- Насанд хүрэгчдийн гадаад онцлог шинж, төрхийг дуурайх (тамхи татах, архи уух, тэдэнтэй адил хувцаслах, нүүр, уруулаа будах, чөлөөт цагаа өнгөрүүлэх хэв маягийг дуурайх гэх мэт) Энэ нь танин мэдэх хэрэгцээ, сонирхол буурч цагийг хөгжөөнтэй, зугаатай өнгөрүүлэх гэсэн хандлага тогтоход хүрдэг.

2. Хөвгүүд "жинхэнэ эр хүний" чанаруудыг (эр зориг, хүч тамир, тэсвэр тэвчээр, хатуужил, үерхэл нөхөрлөлд үнэнч байх чанар гэх мэт) өөртөө төлөвшүүлэхийг эрмэлзэх
3. Нийгэмшихүйн хүрээнд дээрх мэдрэмж нь насанд хүрэгчид ба өсвөр насныхны хамтын үйл ажиллагааны явцад үүснэ.
4. Оюун ухааны хүрээнд "насанд хүрсэн, том хүн" болсон гэсэн мэдрэмж нь мэдлэг чадвараа тэлэх гэсэн хүсэл, тэмүүллээр илэрдэг. Энэ танин мэдэх үйл ажиллагааны хөгжлийг эрчимжүүлнэ





• Өсвөр насны сэтгэцийн хөгжлийн чухал хүчин зүйл үе чацуутантайгаа харилцах харилцаа бөгөөд энэ нь тухайн насны зонхилох үйл ажиллагаа болдог.

• Үе чацуутантайгаа харилцах явцад охид, хөвгүүд нийгмийн зан үйлийн хэм хэмжээ, арга хэрэглүүрийг идэвхтэй эзэмшиж, өөрийгөө болон бусдыг үнэлэх шалгуурыг бий болгож байдаг. Иймээс өсвөр насныхны гол дотны хүн бол найз нөхөд, үе тэнгийнхэн байдаг.





### Бэлгийн харилцаа

• Багш, найз нөхөд, үе тэнгийхэн, интернет, зурагт, сэтгүүл, ном, сонин болон бусад эх үүсвэрээс мэдээлэл авч өөрийн бэлгийн хөгжлөө танин мэдэх, эсрэг хүйсийнхэнтэйгээ хэрхэн ойлголцож, харилцах талаар ойлголттой болсон байдаг.

## Хүсэл мөрөөдөл

- Энэ наснынхан киноны од, поп од, спортын гайхамшигт баатар гэх мэт алдартан болохыг хүсэн мөрөөддөг. Энэхүү байдлын зарим тохиолдол н ь сэтгэлийн хоосрол, ганцаардал, хямралаа даван туулахын тулд хэн нэгнийг хэт тахин шүтэх эсхүл нэг юманд шунан дурлах зан үйлийн шалтгаан болж өгдөг.

Энэ наснхыхан эцэг эхээсээ огт өөр үзэл бодол, дүр төрх, зан үйл илэрхийлэхийг хүсдэг. Энэ нь өөрийн үзэл бодол, хүрээлэн буй орчноо танин мэдэх, оршин тогтнох учир утгын эрэл хийж өөрийн бие хүний талаарх бусдын төсөөллийн би болгохыг хүсдэг. Түүний хамгийн гол зорилго нь өөрнийхөө өвөрмөц давтагдашгүй шинж чанарыг олж нээхэд оршдог.

### Хүүхэд чинь өрийнхөө дараах байдлыг гэнэт өөрчилж болох юм.

- Сонсдог дуу хөгжим
- Хувцасны хэв загвар
- Үсний засалт
- Найз нөхөд
- Итгэл үнэмшил
- Хоол хүнсний сонголт
- Сургуулиас гадуурх үйл ажиллагаа
- Хичээл сурлага, цаашдын сонирхол
- Ирээдүйн зорилго төлөвлөгөө

Хөлд орж байх үедээ аливаа зүйлийг барьж үзэж амандаа хийж туршдаг байсан шигээ энэ насны хүүхэд өөрийн мөн чанарыг олж нээхийн тулд бүхнийг хийхэд бэлэн байдаг. Тэрээр өөрт нь хамгийн сайн тохирох зүйлийг олохын тулд хийж болох юм бүхнийг туршиж үздэхийг хүсдэг.

Тэд томчуудын дүрд “тоглож”, хориглосон зүйл бүхнийг хийж үздэг. Томчуудын, тэр тундаа эцэг эхийнхээ хийдэг бүхнийг тэд дууриаж, хийж үзэхийг хүсдэг. Иймээс эцэг, эх бол хүүхдийн сэтгэхүйн хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл юм.

- Иймээс энэ насны хүүхэд хөнгөмсөг байдаг. Учир өөрт нь ямар нэгэн муу зүйл тохиолдож болно гэдгийг төдийлөн ойлгож хүлээж авдаггүй. Хийж буй зүйлийнхээ улмаас гэмтэж бэртэх, жирэмсэн болох, амь насаа алдаж болохыг тэд б ү р э н дүүрэн ойлгодоггүй.
- Тэд муу зүйл болохгүй гэдэг гэнэн итгэлдээ хөтлөгдөн маш эрсдэлтэй зүйлтэй ч орооцолддог. Тиймд шууд анхаарал хандуулан чанга дуугарах, загнан зандчах б у с дам байдлаар аливаа зүйлээс сэргийлэн, сэрэмжлүүлэх нь зүйн хэрэг

Эцэг, эхчүүд сурган хүмүүжүүлэгч байх ёстой

Хорт зуршил гэж юу болох тухай

Жирэмслэлтийн сөрөг нөлөө

Хайр, дурлал, шохоорхол

Мэдээлэл өгч байх ёстой.
Юмыг нуух тусам хүүхдүүд сонирхдог гэдгийг санах ёстой.

# ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ



# НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ-АЖИЛ ОЛГОГЧ – СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

/Нийгмийн түншлэлийн ажилтан
Д.Буян-Арвижих/





## АГУУЛГА

- Нийгмийн түншлэлийн талаар ерөнхий ойлголт
- 2020-2021 оны хичээлийн жилд хийж хэрэгжүүлсэн ажлууд
- Цаашид хийж хэрэгжүүлэх ажлууд

## НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН АЖИЛТАН АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИЛГО

- МБС-ын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж нийгмийн түншлэлийг бэхжүүлэх
- Мэргэжлийн сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах
- Мэргэжлийн чиг баримжаа олгох, ажилд зуучлах, ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах төгсөгчдөд ажил эрхлэлтийг дэмжих үйлчилгээг үзүүлэх, зөвлөн туслах

## ТҮНШЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

- Түншлэл бол харилцан ашигтай хамтын ажиллагаа
- Түншлэл гэж нэгдмэл хүсэл, сонирхол, нэг зорилготой, харилцан ашигтай, хууль тогтоомжид нийцсэн, тасралтгүй хамтын ажиллагааг хэлнэ.

## ТҮНШЛЭЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

- Хөгжлийн хөдөлгөгч хүч-Ажиллах хүчний хэрэгцээ, ур чадвар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь  олон талын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгждэг
- ААНБ-ын хөдөлмөрийн бүтээмжийг ахиулах, мэргэжилтэй ажилтныхаа эрэлт, ур чадварыг хангах, компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээг ААНБ, МБСБ хамтран хангаж чадна.
- Нэг талаас хөгжлийн болон хөдөлмөрийн зах зээл, ААН-ийн хэрэгцээ, шаардлага, материйллаг боломж, нөгөө талаас энэхүү эрэлтэд суурилж мэргэжилтэй ажилтан бэлтгэж нийлүүлэх МБС-ын салбарын чадавхи, мэргэшсэн байдал нь түншлэлийн хос багана болж өгдөг.



## ТҮНШЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БУСАД АРГА ХЭЛБЭРҮҮДИЙГ ТУХАЙД

- Сургалт эрхэлж буй чиглэл, хүрээний ААНБ-ын судалгаа
- Зорилго, зорилтоо аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хамт олонд хүргэж сурталчлах
- Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөл, “Мэргэжлийн зөвлөл”-д нөлөө бүхий ААНБ-ын төлөөллийг оруулж, түншлэлийн боддоло, үйл ажиллагааг дэмжүүлэх чиглэлээр хамтран ажиллах.
- Үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг чанартай зохион байгуулах
- ИТА, багшийн солилцооны хөтө лбөр хэрэгжүүлэх
- “Төгсөгчдийн холбоо” байгуулах, дэмжиж хамтран ажиллах
- Түнш-ААНБ-ын хамт олонтой спорт, урлагийн тэмцээн, тоглолт, ярилцлага зэргийг төлөвлөж зохион байгуулах
- Ажил мэргэжлийн тэмцээнийг
- МБСБ-тай үр өгөөжтэй хамтран ажилласан ажил олгогчийг урамшуулах, туршлагыг судалж түгээх



### Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль- Түншлэл

**МБС-ын түншлэлийн чиглэлийг тодорхойлсон**

- МБС-ын талаарх бодлого боловсруулахад оролцох
- МБСБ-ын сургалтын орчин нөхцлийг сайжруулах
- ХШҮ-ний тогтолцоог бүрдүүлэх, сургалтын агуулга, стандарт боловсруулахад оролцох
- Үйлвэрлэлийн сургалт, дадлагыг хамтран зохион байгуулах
- Багш нарын мэргэшил дээшлүүлэх
- Мэргэжлийн шалтгалт хамтран авах
- Суралцагчийн сурлагын амжилт, мэргэжлийн ур чадварыг ажил олгогчид мэдээлэх, дадлагажуулах, төгөсгөчийн сонирхолд тургуурлан ажлын байранд зуучлах, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих замаар ажлын байраар хангах
- Багш, ИТА-ны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх
- Үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хамтран явуулах
- /Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль 20 дугаар зүйл 1.1. 6-р зүйл 6. 15.3, 20.3, 24.3,/

## МБСБ-ын түншлэл, хамтын ажиллагаа

| Орц | Үйл явц | Гарц |
|---|---|---|
| • ЕБС-тай хамтран ажиллах (түнш сургуулиуд)<br>• МБСБ, ажил-мэргэжлийн сургалчилгаар түншүүдтэй хамтран хийх<br>• ХЗЗ-ийн эрэлтийн судалгаа, ААНБ-ын захиалга<br>• Элсэлтийн бодлого чиглэл, зохион байгуулалтыг "Мэргэжлийн зөвлөл"-өөр хэлэлцэх<br>• Сургалтын хөтөлбөр хамтран боловсруулах<br>• Хичээлийн шинж жилийн бэлтгэл<br>• Төсөв, хөрөнгө оруулалт<br>• ААНБ-ын хөрөнгө санхүүгийн дэмжлэг | • Сургалтын үйл явцтай ажил олгогч, ИТА-ууд танилцах, зөвлөл<br>• Багш, суралцагчдыг түнш компаниудтай танилцуулах<br>• Үйлдвэрлэлийн дадлагыг чанартай зохион байгуулах<br>• Суралцагчдын мэргэжлийн ур чадвар хандлагын талаархи мэдээллийг түншүүдэд хүргэж ажиллах<br>• Багш, ИТА-ыг солилцуулж ажиллуулах<br>• Хамтарсан судалгаа туршилт хийх<br>• Төсөв, хөрөнгө оруулалт<br>• ААНБ-ын хөрөнгийн дэмжлэг | • Элсэгч, төгсөгчийн харьцаа<br>• Төгсөгчдийн ажлын байртай болсон байдал Түнш ААНБ-д ажилд орсон төгсөгчид<br>• Мөшгих судалгааны дүн<br>• Ажил олгогчдийн сэтгэл ханамжийн байдал<br>• МБСБ-ын зйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн ахиц, өөрчлөлт<br>• Төсөв хөрөнгө оруулалтын дүн, үр өгөөж<br>• ААНБ-ын хөрөнгө санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, үр өгөөч |

| Эрэлт тодорхойлох захиалга өгөх | Шалгуурын дагуу элсүүлэх | Сургалтын хөтөлбөр, сургалт зохион байгуулах | Ур чадварын шалгалт авах | Ажлын байранд хангах, хөдөлмөрийн биржэд байрлуулах |
|---|---|---|---|---|
| МБСҮЗ, Ажил олгогчид хөдөлмөрийн бирж | АО, сургалтын байгууллага, орон нутаг | МБСГ, АО | МБСГ, сургууль АО | АО, хөдөлмөрийн бирж |

## 2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

- Шинээр 27 байгууллагатай гэрээ байгуулсан.
- Цахимаар ажлын санал авах асуулга боловсруулан ААН байгууллагаас авч төгсөгчдийн мөшгөх судалгааны дүгнэлтэд тулгуурлан ажил олгогчдоос ирсэн ажлын саналын дагуу 23 төгсөгчдийг ажилд зуучилсан.
- Мэргэжлийн боловсрол олгох 2,5 жилтэй нийт 23 ангийн 479 оюутан үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагад гарган онлайнаар тайлан мэдээг авч дүн нэгтгэл хийсэн
- Мэргэжлийн анхан шатны боловсролын 1 жилтэй 7 мэргэжлийн ангийн 103 суралцагч төгсөлтийн өмнөх дадлагад гаргаж. Курсийн ажлаар дүгнэн дүн нэгтгэл хийсэн
- "МИАТ" ТӨХК-тай Техник Технологийн тэнхимийн мехатроникч, цахилгаанчин, гагнуурчин, автомашин засварчин мэргэжлийн багш нар болон бусад мэргэжлийн багш, сургалтын албаны ажилтан, агаарын хөлгийн үйлчилгээний ажилтны суралцагчдыг танилцуулах ажлыг зохион байгуулсан.
- 3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмжийг оюутан суралцагчид болон эцэг эх асран хамгаалагч нарт танилцуулсан
- 4 Эцэг эхийн эргүүл"-ийг эцэг эх, асран хамгаалагчийн хүүхдэдээ тавих анхаарал халамж сайжруулах, сургуулиас зохион байгуулах аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах зорилгоор хамтран ажилласан.

# 2020-2021 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

## Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль- Түншлэл

- ҮУПК Нийгмийн түншлэлийн хуудас линк - https://www.facebook.com/ganditunshlel
- Аж ахуй нэгж байгууллагаас ажлын санал авах- https://www.facebook.com/groups/220304893025538
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа - https://forms.gle/fjMVqrC7itLfNi5aA
- Төгсөгчдийн мэдээлэл - Ажил эрхлэлт - Сэтгэл ханамжийн судалгаа- https://forms.gle/7Dfu7MsfbAZooar1A
- ҮУПК Нийгмийн түншлэлийн- Ажил олгогч- Төгсөгчдийн нэгдсэн групп- https://forms.gle/icmcSgaEf63EkWYLA
- Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа судалгааг- https://www.facebook.com/ganditunshlel




**Жил бүр шинээр хамтран ажиллах гэрээ хийсэн тоон харьцуулалт**




**Сүүлийн 5 жилд нийт 101 хамтран ажиллах гэрээ байгуулсан.**

# Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 3 жилээр харьцуулсан үзүүлэлт






# Цаашид хийж хэрэгжүүлэх ажлууд

## Мэргэжлийн зөвлөл



**ТЭМДЭГЛЭЛ**

## ТЭМДЭГЛЭЛ



**1. Гэр ахуйн нөхцөлд галын аюулаас урьдчилан сэргийлэх.**
**2. Ковид19 вирусээр урьдчилан сэргийлэх зөвлөмж**

/ХАБЭА-н ажилтан Б.Билгүүнбаяр/



**Гарчиг**

- Гэр ахуйн нөхцөлд галын аюулгүй ажиллагааг хангах.
- Хэрэв та галын аюулд өртвөл анхаарах зүйлс.
- Гал гарах хүчин зүйлс.
- Корона вирусээс урьдчилан сэргийлэх зөвлөмж.

## Гэр ахуйн нөхцөлд галын аюулгүй ажиллагааг хангах.

- Жил бүр уртасгагчаас болж гарсан ахуйн гал түймрийн тоо 3000-д хүрдэг ба үүний улмаас 270 орчим хүн тодорхой хэмжээгээр гэмтэж, 50 хүн амь насаа алддаг болохыг судалж тогтоожээ. Энэ төрлийн гал гарах шалтгаануудын ихэнх нь богино холбоо үүсэх, ачаалал ихдэх, уртасгагчийн утсыг зориулалтын бусаар ашиглах, гэмтээх зэрэг байсан байна.
- Өнөөдөр бид уртасгагчийг хэрхэн аюулгүй ашиглах талаар зарим зөвлөмжтэй танилцана.
- ҮҮНД:
- Уртасгагчийг зөвхөн шаардлагатай үед, түр зуурын цахилгааны эх үүсвэр болгож ашиглана. Уртасгагчийг байнгын цахилгааны эх үүсвэр болгож ашигладаггүй.
- Уртасгагчийн сэрээ унасан, гэмтсэн, тахийж мурийсан, суларсан бол бүү засаж хэрэглэ. Уг уртасгагчийг акталж шинэ уртасгагч ашигла.
- Уртасгагч болон адаптер стандартын газардуулгын оронд бүү ашигла. (3 сэрээтэй бол 3 сэрээтэй эм залгуурт л залга.Залгуурын нүхэнд тааруулахын тулд 3 дахь сэрээг тайрахыг хориглоно.
- Тухайн тоног төхөөрөмжид тохирсон уртасгагч ашигла. Уртасгагчийн утасны диаметр нь тухайн төхөөрөмжийн үндсэн утастай ижил эсвэл том байх ёстой.
- Гадаа залгаж ажиллуулах гэж байгаа бол зөвхөн гадаа ашиглах зориулалттай уртасгагчийг ашигла.
- Уртасгагчийн утсыг таазны цаагуур, хананы дундуур гүйлгэж болохгүй. Хавчигдах, хүн бүдрэх аюул үүсгэх байрлалд бүү бэхэл. (жнь: хаалганы ойролцоо, коридорт, хивсэн доор гэх мэт).
- Хэрэглэхийн өмнө үргэлж гэмтсэн, шалбарсан эсэхийг нь шалгаж бай. Гэмтсэн, халдаг, шалбарсан уртасгагчийг шууд устга.
- Уртасгагчийг хэзээ битгий утаснаас нь татаж салга. Заавал залгуураас нь татаж салгаж бай.
- Галлагааны улирлын өмнө зуух, пийшин, зэрэг дулаан үүсгэгч хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, илэрсэн гэмтлийг арилгах
- Үнс нурмаа ухаж бэлтгэсэн хаалт, таглаа бүхий нүхэнд асгах.

## Хэрэв та галын аюулд өртвөл дараах зүйлсийг анхаарна уу.

- Галын аюул гарсан үед гарц, хаалга хаана буйг сана.
- Өрөөнөөс гарч буй сүүлийн хүн хаалыг түгжилгүй хаагаад л орхих хэрэгтэй. Учир нь гал сөнөөгчид аврах ажиллагаа хийхэд нь саад болж болзошгүй
- Хамгийн ойрын гарцаар гар.
- Ямар ч тохиолдолд цахилгаан шат бүү хэрэглэ
- Утаа болон хорт хийнээс сэргийлэхийн тулд аль болох тонгойж доогуур яв.
- Шалтай ойр байх тусам агаар цэвэр байдаг тул шаардлагатай бол мөлх.
- Боломжтой бол ам, хамраа даавуугаар халхалвал амьсгалахад амар болно.
- Бүү сандар. Саруул ухаанаар бодох нь амиа аврахад чинь тус болно.
- Хаалттай байгаа хаалгыг гарын араараа тэмтэрч мэдрээгүй бол бүү онгойлго.
- Өөр гарц үгүй тохиолдолд хаалганы зай завсрыг боломжтой зүйлээрээ халхал
- Амьсгалах боломжтой байгаа бол хаалгатай аль болох ойр бай.
- Өрөөг агааржуулахын тулд цонхыг хагал
- Хэрэв хувцас чинь галд өртвөл зогс, хэвт, өнхөр, гүйж болохгүй.
- Таны хамтрагсдын нэг галд өртвөл хүрэм, хөнжил, гудас мэтийн зүйлээр түүнийг ороо




## Гэр ахуйн нөхцөлд гал гарах хүчин зүйлс

- Тог цахилгаан
- Тамхины иш
- Оч
- Цахилгаан цахих
- Хүний сонор сэрэмж алдсанаас үүсэх гал.

## Гал түймрийн ангилал

**Ангилал: А**

- **Шатах материал:** Угиж шатдаг органик үүсэлтэй хатуу шатах материалууд /мод, нүүрс, цаас, резин, нэхмэл материал/ зэрэг
- **Гал унтраах хэрэгсэл:** Гал унтраах бүх хэрэгслүүд /ус, хөөс/
-

**Ангилал: В**

- **Шатах материал:** Шатах шингэн болон халалтанд хайлдаг хатуу бодис материалууд /мазут, бензин, лак, масло, каучук/ зэрэг
- **Гал унтраах хэрэгсэл:** Бүх төрлийн хөөс нунтаг цацруулсан усаар
-

**Ангилал: С**

- **Шатах материал:** Шатдаг хий /устөрөгч ацетилен, нүүрстөрөгч/
- **Шатах материал:** Идэвхигүй хий / нүүрсхүчил, азот/
-

**Ангилал: Д**

- **Шатах материал:** Металлууд болон тэдгээрийн хайлшууд /кали, натри, хөнгөн цагаан/
- **Гал унтраах хэрэгсэл:** Нунтагууд
-

**Ангилал: Е**

- **Шатах материал:** Хүчдэлтэй цахилгаан тоног төхөөрөмжүүд
- **гал унтраах хэрэгсэл:** Нунтаг нүүрсхүчлийн хий

## Корона вирус /covid19/-ээс урьдчилан сэргийлэх зөвлөмж

- Гэр бүлийн гишүүдээс шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэж гэр бүлийн бусад гишүүдээс тусгаарлах боломжийг гэртээ бий болгоорой.
- Ковид19 илрэх шинж тэмдэг.
- - Халуурах.
- - Ядрах
- - Ханиалгах
- - Шалтгаангүй бие өвдөх
- - Нус гоожих эсвэл хамар битүүрэх
- - Гүйлгэх
- - Толгой өвдөх
- - Амьсгал давхцах



## Хүнс худалдан авахын өмнөх зөвлөгөө.

- Худалдан авах хүнсний жагсаалтыг гаргах.
- Дэлгүүрт очихоос өмнө гэрийнхээ хүнс хадгалах нөхцөл байдлыг шалгах.
- Худалдан авах хүнсээ хийх уут, тор, савыг угааж цэвэрлэн ариутгах.
- Дэлгүүрийн дараалалд зогсож байхдаа хүн хоорондын зайг барих амны хаалт, бээлийг заавал хэрэглэх.
- Дэлгүүрт орохдоо заавал QR код уншуулж халуунаа хэмжүүлж гараа ариутган нэвтрэх.
- Ковид19 вирусийн халдварт эрсдэлтэй бүлгийн хүмүүс дэлгүүр явахгүй байхыг хичээх.



## Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

- Гараа сайтар савандаж угаах, халдваргүйжүүлэгч хэрэглэх;
- Ханиах, найтаах үедээ ам хамраа таглах, амны алчуур хэрэглэх;
- Мах, өндгийг гүйцэд болгож идэх;
- Амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн хүнтэй ойр байхаас зайлсхийх;
- Мал, тэжээвэр болон зэрлэг амьтантай хүрэлцэхгүй байх;
- Шүүрхий мах, махан бүтээгдэхүүн идэхгүй байх;
- Түүхий ус уухгүй байх;
- Далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг сайтар буцалгаж хэрэглэх;
- Арьс, салстаа гэмтээхгүй байх;
- Мал, амьтны зах, аж ахуйгаар орохгүй байх;
- Халдварын эрсдэлтэй бүс нутагт аль болох зорчихгүй, зочин урихгүй байх;
- Хүн ихээр цугларсан газарт аль болох очихгүй байх;
- Зэрлэг амьтдын мах, эд эрхтэнг хүнсэнд хэрэглэхгүй байх;
- Нус, цэрээ ил задгай хаяхгүй байх.

## Хүнс худалдан авахын өмнөх зөвлөгөө.

- Худалдан авах хүнсний жагсаалтыг гаргах.
- Дэлгүүрт очихоос өмнө гэрийнхээ хүнс хадгалах нөхцөл байдлыг шалгах.
- Худалдан авах хүнсээ хийх уут, тор, савыг угааж цэвэрлэн ариутгах.
- Дэлгүүрийн дараалалд зогсож байхдаа хүн хоорондын зайг барих амны хаалт, бээлийг заавал хэрэглэх.
- Дэлгүүрт орохдоо заавал QR код уншуулж халуунаа хэмжүүлж гараа ариутган нэвтрэх.
- Ковид19 вирусийн халдварт эрсдэлтэй бүлгийн хүмүүс дэлгүүр явахгүй байхыг хичээх.








**Хэт их мэдээллээс зайлсхийж, сөрөг мэдээлэлд авталгүй эерэг байж, цахим орчинд бага цаг зарцуулаарай.**



## ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ



**Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж**
**ЦАХИМ НОМЫН САН**

/Номын санч Х.Батжаргал/



## СОНА гэж юуг хэлэх вэ!




## Номын сангаас зохиох соёл олон нийтийн ажил



1. Сургуулийн номын сангийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг бол СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ байдаг уг ажлын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол өндөр учир Номын сангийн эрхзүйн баримтууд, нэр томъёоны толиудад энэ тухай ямар нэг байдлаар тусгадаг.

Жишээ нь: “Номын сангийн үлгэрчилсэн дүрэм”-д: Номын сангийн гүйцэтгэх үүрэг: 4.1, Номын сангийн тухай хууль: 14.3.5.номын сангаас зохиож байгаа соёл, олон нийтийн ажилд оролцох, номын сангийн үйлчилгээний талаар санал оруулах

## Уншихгүй бол сэтгэхээ болино Ухаан далай номоос ихтэй



СОНА гэж юуг хэлэх вэ! Номын сан болон түүний уншигчдад тодорхой хэмжээгээр ашиг тустай, урьдчилан төлөвлөгдсөн үйл ажиллагаа эсвэл үйл явдал (Эсвэл цуврал үйл ажиллагаа) -ыг номын сангийн соёл олон нийтийн ажил гэнэ





Жишээ нь: Үлгэрийн цаг, зохиогчтой хийх уулзалт, чанга уншлага, зуны уншлагын хөтөлбөр уншсан номынхоо агуулгаар хэсэгчилсэн ярилцлага уулзалт, бичиг үсгийн баяр, АХА тэмцээн, Ном эрдмийн баяр г.м. хөгжилтэй орнуудад номын сангаас зохиосон соёл олон нийтийн ажлын статистикийг тусад нь гаргаж, түүнийг тодорхой шалгуурын дагуу эрэмбэлж байдаг.

Ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр дамжуулан сургалтыг дэмжих, танин мэдэхүйг хөгжүүлэх, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдрах ухаанд сургах зорилгоор номын сангийн агуулга, хэлбэрийг баяжуулах, төрөл бүрийн соёл олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах



Мэргэжлийн боловсролын сургалттай манай сургуулийн хувьд оюутан сурагчдыг мэргэжилдээ дуртай болж зөв төлөвшихөд нь СОНА-ыг олон төрөл хэлбэрээр зохиох боломж их байдаг.

Жишээ нь: сүүлийн улиралд анги даасан 8 н багштай хамтарч 220 гаруй оюутан сурагчдыг хамруулсан арга хэмжээ зохиоход ихэнх оролцогсод сэтгэл ханамжтай дахин оролцох хүсэлтээ тавьж байсан нь манай оюунлаг багш нарын идэвхийг харуулж байлаа.



**СОНА зохион байгуулахад анхаарах зүйлс**
**Удирдамж, Төлөвлөгөө, Хөтөлбөр**

Сайн төлөвлөгөө нь аливаа ажлыг үр дүнтэй зохион байгуулах үндэс болдог. Төлөвлөгөөнд дараах зүйлсийг анхаарна.
Зорилго, хөтөлбөр,цаг хугацаа, тухайн нэгж ажлыг хариуцаж хийх ажилтан, зарцуулах төсөв, г,м
зорилго, ач холбогдол, зохион байгуулалт ,тайлан, дүн шинжилгээ




Арга хэмжээг зохион байгуулснаар Номын сан болон оролцогч уншигчдад ямар ашиг тустай байх вэ? гэсэн үндсэн шалгуурыг хангаж байх ёстой.
Тоо бус, харин чанарт анхаарч зорилгоо тодорхойлно. Зорилгод олон зүйл бичих шаардлагагүй, ганц өгүүлбэрт багтаагаад оновчтой тодорхойлох хэрэгтэй.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Ном сурах бичгийн ашиглалт-төрөөс баримтлах бодлого

Засгийн газраас сурах бичгийн хүрэлцээг сайжруулах зорилгоор 2019-2020 оны хичээлийн жилд “Сурах бичгийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол”-ыг гаргасан. Үүнтэй холбоотойгоор БШУЯ-ны сайдын тушаалаар “Сурах бичгийг төлбөртэй ашиглуулах журам”-ыг ч баталсан юм.

СОНА зохион байгуулсанаар ямар үр дүн гарах вэ? гэдгийг урьдчилан төсөөлж бичнэ.
Тухайлбал сурагчдын мэдлэгийг тэлэх чадварыг хөгжүүлэх тэдний хоорондын харилцааг идэвхжүүлэх багш ажилтнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг цаг хугацааны дагуу гүйцэтгэх үйлдэл зохион байгуулалтыг хийхдээ бусад хүмүүсийн дэмжлэгийг авах шаардлагатай зүйлсээ бүрдүүлэх, тайз засах, уншигчиддаа сурталчлах, тухайн өдрийн арга хэмжээг хариуцах, хөтлөх г.м. төлөвлөлтөө эргэн хянах
Арга хэмжээний дараа тайлан дүн шинжилгээ хийх



ТҮРЭЭСИЙГ СУРАХ БИЧГИЙН ҮНИЙН ДҮНГИЙН 40 ХУВИАС ХЭТРҮҮЛЭХГҮЙ

Өөрөөр хэлбэл, 1200 төгрөгийн сурах бичгийг номын сангаас авч ашиглахдаа 500 орчим төгрөг төлөх аж. Учир нь, сурагчид 2019-2020 оны хичээлийн жилд шинэ сурах бичиг ашиглах учраас ийм байдлаар тогтоожээ.

## ТҮРЭЭСЭЭР АШИГЛАЧИХААД БУЦААН ОЛГОХ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОНО

Сурах бичгийг 2009 оноос хойш өнөөг хүртэл 1200-5000 төгрөгийн үнэтэйгээр худалдаалж буй. Дунд болон ахлах ангийн нэг сурагч бүх хичээлийнхээ сурах бичгийг худалдан авахад дунджаар 50-60 мянган төгрөг болдог. Үүнийг харахад харьцангүй боломжийн мэт боловч хамгийн гол нь зах зээл дээр энэ үнээр борлуулдаггүй.



## ТЭМДЭГЛЭЛ

## ТЭМДЭГЛЭЛ



## СУРГАЛТЫН ГОЛ ЗОРИЛГО  НЬ

Багш,ажилтны ажлын байран дээрх хөгжлийн асуудал нь тэдний ажлын байран дээрх тогтворгүй байдал,дотоод дүрэм журмыг баримтлах,ажиллах урам зоригийн нэгээхэн хөшүүрэг бөгөөд сургалтын гол зорилго нь тэднийг дэмжих, хөдөлмөрийн бүтээмжийг нь нэмэгдүүлэх улмаар байгууллагын сургалтын үйл ажиллагааг сайжруулах явдал юм.


**ЭМХЭТГЭЛИЙГ НЭГТГЭСЭН:** М.Алтанцэцэг /Эдийн засаг мэргэжлийн багш,Ерөнхий эрдмийн тэнхмийн эрхлэгч,МБС-ын Тэргүүлэх багш/

**РЕДАКТОРЛОЖ, ХЯНАСАН:** Б.Мядагбадам /Сургалтын албаны менежер/

**ЭХ БЭЛТГЭСЭН:** А.Дэлгэрмөрөн /Мэдээллийн технологийн багш/



2021 оны 03 сар



@rajivgandhicolleges    info@pas.mn    pas.mn